



МОНГОЛЫН НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ
(СОРОСЫН САН)

ХУУЛЬ ХЭРХЭН БҮТДЭГ ВЭ?

Иргэдэд зориулсан гарын авлага



Боловсруулсан ;

Д.Цолмон

Л.Лувсанжамц

Л.Баян-Алтай

АГУУЛГА

Нэгдүгээр бүлэг: Хууль гэж юу вэ?	2
1.1. Хуулийн тухай, бидний амьдралд хууль нөлөөлөх нь	3
1.2. Хуулийн төрөл	16
Хоёрдугаар бүлэг. Хууль хэрхэн бүтдэг вэ?	19
2.1. Хууль санаачлах, төсөл боловсруулах ажиллагаа	20
2.2. Хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах, санхүүжүүлэх	24
2.3. Хуулийн төслийг өргөн мэдүүлэх	27
Гуравдугаар бүлэг. Хуулийн төслийн хэлэлцүүлэг	30
3.1. Хуулийн төсөл хэлэлцэх, батлах үе шат	31
3.2. Хуулийн төслийг байнгын хороогоор урьдчилан хэлэлцэх	32
3.3. Хуулийн төслийг УИХ-аар хэлэлцэх	35
3.4. Хуулийг ёсчлох, нийтлэх, мэдээлэх	41
Дөрөвдүгээр бүлэг. Хууль бүтээх үйл ажиллагаан дахь иргэний оролцоо	44
4.1. Иргэний оролцооны тухай товч ойлголт	45
4.2. Лобби ба хууль	50
Ном зүй	56

Удиртгал

“Төр төвшин бол түмэн олон амгалан” гэж Монголчууд бид ярьдаг билээ. Эрхэм уншигч таны билгийн мэлмийг мялааж, ухаан далайд тань нэгээхэн дусал нэмэх энэхүү гарын авлагыг толилуулж байгаадаа баяртай байна.

“Хууль хэрхэн гардаг” тухай гарын авлага нь иргэдэд хууль, эрх зүйн нийгэмд гүйцэтгэх үүрэг, хууль батлан гаргах үйл явц, тэдгээрт иргэд хэрхэн оролцох боломжийн талаар өгүүлж, иргэдийн хуулиа дээдлэн, төрийнхөө үйл хэрэгт тус нэмэр болж амьдрах сэтгэлгээг дэмжихэд өчүүхэн төдий хувь нэмэр оруулах зорилгоор бүтээгдсэн билээ.

Бид 1992 онд ардчилсан Үндсэн хуулиа баталж, хүний эрх, эрх чөлөө, хүн бүр хуулийн өмнө адил тэгш байх шударга зарчим, төрийн үйл хэрэгтээ сонгох, сонгогдох замаар адил тэгш оролцох боломж зэргийг баталгаажуулж, хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгон тунхагласан гэдгийг бид бүхэн мэднэ.

Энэ эрхэм зорилгод хүрэхэд иргэн бүрийн хувь нэмэр, оролцоо туйлын чухал байдаг. Ялангуяа төрийн бодлогыг тодорхойлох гол хэрэгсэл болох хууль гарах үйл ажиллагаанд иргэд өөрт олгогдсон боломжоо ашиглан идэвхтэй оролцож, өөрийн санаа бодлоо нийгмийнхээ хөгжилд сэтгэл харамгүй зориулж байх нь ардчилсан улсын иргэн та бидний хүлээх ариун үүрэг гэж бодном.

Нэг талаас төр нь хууль тогтоох замаар иргэдийнхээ эрх ашгийг хамгаалж, нийгмийг эмх цэгцтэй байлгах зорилготой байдаг хэдий ч энэ нь дан ганц төр бүгдийг шийднэ гэсэн үг биш ажээ. Орчин үеийн ардчилсан улс орнууд бодлого тодорхойлох, хууль батлах зэрэгт иргэдийг өргөнөөр оролцуулах болсноор нилээдгүй амжилтыг олж байна гэж үздэг. Иргэдийн оролцоо, мэдээлэл, зөвлөгөөн зэрэг нь төрийн бодлогыг ул суурьтай боловсруулах, түүний хэрэгжилт үр дүн нь сайн байх, төрд итгэх итгэл нэмэгдэх, ардчиллыг улам бэхжүүлэхэд ихээхэн ашиг тусаа өгдөг байна.

Гарын авлагыг хэвлүүлэн гаргах ажлыг санаачилж, холбогдох бүх зардлыг санхүүжүүлсэн Монголын нээлттэй нийгэм хүрээлэнд (Соросын сан) уншигч олон түмнийхээ өмнөөс талархалаа илэрхийлж байна.

Уг гарын авлагыг эрхэм уншигч Та билэг оюундаа тунгаан бодсоноо биет ажил болгоно гэдэгт бид гүнээ итгэж байна.

***Дуслыг хураавал далай,
Дуулсныг хураавал эрдэм болой***

Гарын авлагыг бичсэн баг
Д.Цолмон
Л.Лувсанжамц
Л.Баян-Алтай

БҮЛЭГ 1. Хууль гэж юу вэ?

1.1. Хуулийн тухай, бидний амьдралд хууль нөлөөлөх нь

1.2. Хуулийн төрөл

Бид энэхүү бүлгээс эрх зүйн хэм хэмжээ, түүний хэм хэмжээ илрэл болох хуулийн талаарх ойлголт, бидний амьдралд хэрхэн нөлөөлж, ямар үүрэг гүйцэтгэдэг болох, хуулийн төрөл, тэдгээрийн хүчин чадал, харилцан хамаарлын тухай мэдэх болно.

1.1. ХУУЛИЙН ТУХАЙ, БИДНИЙ АМЬДРАЛД ХУУЛЬ НӨЛӨӨЛӨХ НЬ

Эрх зүй, хуулийн тухай үндсэн ойлголт

Бид хууль хэрхэн гардаг талаар мэдэхийн тулд хууль, эрх зүй гэж юу болох, түүний онцлог шинж чанар, та бидний амьдралд ямар ач холбогдолтой байж, ямар үүрэг гүйцэтгэдгийг мэдэх шаардлагатай билээ.

Аливаа хүн өөрийнхөөрөө оршин тогтнож, амьдрахын тулд нийгмийн харилцаанд оролцох нь зайлшгүй. Та бидний өдөр тутам оролцож байгаа харилцаануудыг зохицуулдаг олон төрлийн хэм хэмжээ байдаг бөгөөд түүний нэг нь эрх зүйн хэм хэмжээ юм. Тэгвэл хэм хэмжээ гэж юуг ойлгох вэ? Аливаа үйлдэл, үйл ажиллагааг хийхэд дагаж баримтлан, мөрддөг зан үйлийн дэг журмыг хэм хэмжээ гэж ойлгож болно. Бид төдийлөн анзаардаггүй боловч амьдралдаа маш олон хэм хэмжээг дагаж мөрдөж биелүүлсээр л явдаг.



Нийгмийн хэм хэмжээнд:

- зан заншлын
- улс төрийн
- эдийн засгийн
- ёс суртахууны
- шашны
- гоо зүйн
- эрх зүйн хэм хэмжээ орно

Эдгээр нийгмийн хэм хэмжээнүүдээс эрх зүйн хэм хэмжээ нь ямар онцлогтой байдаг вэ гэдгийг авч үзэх хэрэгтэй. Ингэснээр төрөөс батлан гаргаж байгаа хууль тогтоомжуудыг иргэн хүн заавал дагаж мөрдөх шаардлагатай юу үгүй юу гэдэг нь тодорхой болох юм.

Эрх зүйн тухай

Бид өдөр тутам, байнга эрх зүйн харилцаанд оролцож байдаг. Эрх зүйн талаарх ойлголт, түүнд хандах хандлага нь нийгмийн хөгжлийг даган өөрчлөгдсөөр иржээ. Аливаа нийгэмд ардчилал, хүний эрх, эрх чөлөө, тэгш эрх, аюулгүй байдлын найдвартай баталгаа, нийгмийн харилцааны чухал тохируулга нь “эрх зүй” байдаг.

ХЭМ ХЭМЖЭЭ:
Аливаа үйлдэл,
үйл ажиллагааг
хийхэд дагаж
баримтлан,
мөрддөг зан
үйлийн дэг
журам.

ЭРХ ЗҮЙ:
Нийгмийн
харилцааг
зохицуулахаар
төрөөс
тогтоодог, бүх
нийтээр заавал
дагаж мөрдөх
эрх зүйн хэм
хэмжээний
нийлбэр цогц.

Энэхүү тодорхойлолтоос үзвэл эрх зүй бол нийгмийн харилцааг зохицуулагч гэсэн гол утга харагдаж байна. Нийгмийн харилцааг зохицуулагч болохынхоо хувьд энэ нь өөрийн гэсэн хэм хэмжээнүүдээр илрэн гарна.



Эрх зүйн хэм хэмжээ нь нийгмийн харилцааны бүхий л элемент бүрийг нэг бүрчлэн зохицуулах биш харин харилцааны бүх төрөлд өөрийн зохицуулалтыг хийдэг. Иймээс эрх зүйн хэмжээнээс гадна нийгмийн бусад хэм хэмжээнүүд тухайлбал, ёс суртахууны, зан заншлын, улс төрийн, шашны гэх мэт хэм хэмжээнүүд нийгмийн харилцааг зэрэгцэн зохицуулдаг билээ.

Өөрөөр хэлбэл, аливаа ашиг сонирхлыг зохицуулахад эрх зүйн хэм хэмжээнээс гадна нийгмийн бусад хэм хэмжээнүүд шийдвэрлэх нөлөөтэй байдаг бөгөөд харилцаанд оролцогчдын нийгэмд биеэ авч явах байдлын ердийн горим, журмыг бий болгодог билээ.

Өөрийн эрхийг өөрийн үүргээр хэмждэг тэр л хүн шударга төвшин байдаг.
Ж.Лакордер

Эрх зүйн хэм хэмжээ бусад хэм хэмжээнээс ялгагдах нь

1. Төрөөс тогтоогдон гарч, заавал хэлбэржин бичигдсэн байна.

Эрх зүйн хэмжээний нийгмийн бусад хэм хэмжээнээс ялгагдах хамгийн анхдагч шинж нь төрөөс тогтоогдон гардаг явдал бөгөөд энэхүү хэм хэмжээг тогтоогч нь хуулиар олгогдсон эрхтэй, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага байдаг. Манай улсад хуулийг зөвхөн Улсын Их Хурал батлан гаргана. Энэ үйл ажиллагааны талаар бидний цааш үзэх “Хууль хэрхэн бүтдэг тухай” бүлгээс илүү тодорхой мэдэх боломжтой. Хэлбэржин бичигдсэн байх шинж нь бидний ярьдаг бичмэл хийгээд бичигдээгүй хууль гэдэг ойлголттой илүүтэй холбогдоно.



Бичигдээгүй хууль гэдэгт зан заншлын болон ёс суртахууны зэрэг нийгмийн харилцааг зохицуулж байдаг бусад хэм хэмжээнүүдийг ойлгодог. Энэ нь хэлбэржиж, бичигдээгүй мөртөө нийгмийн харилцааг

зохицуулж, түүний хөгжлийг даган уламжлагдан шинэчлэгдэж байдаг байна. Тэгвэл бичмэл хууль гэдэг нь төрөөс гаргасан хууль тогтоомжийг ойлгох бөгөөд бичигдэн гарахгүйгээр түүнийг бүх нийтээр дагаж мөрдөх, биелүүлэх боломжгүй нь ойлгомжтой.

Жишээ, хэм хэмжээ

Монголчууд бидний “Цагаан сар” хэмээн тэмдэглэдэг баяраар ахмад настандаа хүндэтгэл үзүүлж золгох ёс, жаяг, үйлдлийг хуульчилсан байдаг уу? Хаврын тэргүүн сарын шинийн нэгэн, хоёронд бүх нийтээр амрах баяр ёслолын өдөр гэж Хөдөлмөрийн хуулиар зохицуулсан байдаг. Энэ тохиолдлын хууль зүйн зохицуулалт нь ажил олгогч нарын хувьд ажилтнуудаа энэ хоёр өдөр ажиллуулахгүй байх үүргийг бий болгож, ажилтнуудад амрах эрхийг бий болгож байна. Харин ёслол, хүндэтгэлийг хэрхэн үзүүлэх, яаж золгох вэ гэсэн дэг журам нь хуулиар биш харин зан заншил, шашин, ёс суртахууны зэрэг нийгмийн бусад хэм хэмжээгээр зохицуулагддаг билээ.

Өөрөөр хэлбэл, бүх нийтэд адил тэгш байх буюу хүн бүр түүнийг дагаж мөрдөх үүрэгтэй байх үүднээс бичигдмэл хэлбэртэй байх шаардлагатайн зэрэгцээ албан ёсоор нийтлэгдэх ёстой байдаг байна. Хууль хэвлэгдэн гарах харилцааг хэрхэн зохицуулсныг дараа авч үзэх болно.



Хуулиас гадна
нийгмийн
харилцаанд зан
заншил, уламжлал,
ёс суртахууныг
дээдлэх нь маш
чухал байдаг.

2. Эрх зүйн хэм хэмжээ нь нийгмийн харилцааг тогтоосон, зөвшөөрсөн, хориглосон байдлаар зохицуулна.

Эрх зүй нь үндсэндээ “тогтоосон”, “зөвшөөрсөн”, “хориглосон” гэсэн гурван хэм хэмжээгээр нийгмийн харилцааг нэг талаас зохицуулж, нөгөө талаас хамгаалж байдаг. Энгийн утгаар авч үзвэл зохицуулах үүрэг нь тогтоосон, зөвшөөрсөн хэм хэмжээгээр илүүтэй

илэрдэг бол хориглосон хэм хэмжээгээр хамгаалах үүрэг нь тодорхойлогддог байна.



Тогтоосон хэм хэмжээ гэдгийг үгийн үндсээс нь үзсэн ч тогтоож, хэлбэршүүлж байгаа буюу түүнийг эрх зүйн харилцаанд оролцогч өөрийн хүсэл зориг, ашиг сонирхолд нийцүүлэн өөрчлөх боломжгүй бөгөөд заавал дагаж мөрдөх ёстой гэсэн ойлголт байх ажээ. Тогтоосон хэм хэмжээ нь үүрэг болгосон зохицуулалтыг агуулдаг ба ийм зохицуулалтыг бид бүхэн ямар ч хуулиас олж харах боломжтой.

Жишээ, эрх зүйн хэм хэмжээ

УИХ-ын тухай хуульд “УИХ-ын гишүүний бүрэн эрхийн хугацаа **4 жил байна**” гэж тогтоосон байна. Энэ хугацааг багасгах эсхүл уртасгах боломж гагцхүү хуулийн энэ зохицуулалтад өөрчлөлт оруулж байж л гарна.

Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хуульд “**Хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулна**” гэсэн байдаг. Энэ нь зөвшөөрсөн бас хориглосон биш харин үүрэг болгосон зохицуулалт юм. Хэрвээ хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулж болно гэсэн байх тохиолдолд тухайн гэрээг талууд бичгээр хийгээд амаар байгуулж болохыг зөвшөөрсөн зохицуулалт болох юм.

Түүнчлэн Иргэний хуульд иргэд хоорондын зээлийн гэрээнд хүү төлөхөөр талууд тохиролцож болно гэсэн байдаг. Эндээс **хүү тогтоож болно** гэдэг нь зөвшөөрсөн заалт юм. Харин тогтоосон заалт хаана нь байх ёстой вэ гэвэл “Хүү тогтоосон бол зээлийн гэрээг бичгээр хийнэ. Энэ шаардлагыг хангаагүй бол хүү авах эрхээ алдана” гэснээс “**бичгээр хийх**” гэдэг нь тогтоосон заалт юм.

Дээрх жишээнээс харахад тогтоосон заалтын цаана түүнийг биелүүлэх үүрэг үүсдэг байна. Хэрвээ энэ үүргээ биелүүлээгүй бол нэг талаас хариуцлагын тухай яригдахын зэрэгцээ нөгөө талаас эрхээ алдах нөхцөл бүрдэж болдог байна.



Тэгвэл зөвшөөрсөн хэм хэмжээний тухай хамгийн энгийнээр хэлбэл эрх зүйн харилцаанд оролцогч болох иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд тухайн үйлдэл, үйл ажиллагааг хийх боломжийг төрөөс хуулиар олгож байгаа ойлголт юм.

Өөрөөр хэлбэл, зөвшөөрсөн зохицуулалт нь танд хуулиар олгогдож байгаа боломж бөгөөд энэ боломжийг ашиглах эсэх нь таны хүсэл зориг буюу сонирхлоос шалтгаалах асуудал байхын зэрэгцээ энэ нь

Иргэд бидний анхаарах гол зүйл бол хуулиар тогтоосон заалтыг заавал дагаж мөрдөж, биелүүлж байх үүрэгтэй.

сонгох боломжтой байдгаараа бас онцлог юм. Зөвшөөрсөн заалтын илрэх хэлбэр нь ихэнх тохиолдолд “**эрхтэй**”, “**болно**” гэсэн үгээр илэрч байдаг.

Жишээ, зөвшөөрсөн хэм хэмжээ

Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд заасан сэжигтний эрхээс дурдвал, “...мэдүүлэг өгөх, мэдүүлэг өгөхөөс татгалзах; эх хэлээрээ болон мэддэг хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах; хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, орчуулагч, хэлмэрч, шинжээчийг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах; өөрийгөө өмгөөлөх, хуульд заасны дагуу өмгөөлөгч авах; өмгөөлөгчтэйгээ ганцаарчлан уулзах **эрхтэй**” гэх мэтээр аль ч хуулиас эрх олгосон зохицуулалтыг харж болно.

Харин “**болно**” гэсэн үгээр төгсөж илэрхийлэгдэж байгаа зохицуулалтын цаана зарим тохиолдолд зөвшөөрсөн хэм хэмжээний зэрэгцээ тогтоосон хэм хэмжээ илэрхийлэгдэж болдог.



Жишээ, Зөвшөөрсөн ба тогтоосон хэм хэмжээ

Монгол Улсын Иргэний хуулийн 16 дугаар зүйлийн 4-т “16-аас 18 хүртэлх насны иргэн хоршооны гишүүн **байж болно**”, 39 дүгээр зүйлийн 2-т “Нэг этгээд хүсэл зоригоо илэрхийлэн хэлцэл **хийж болно**” гэж зөвшөөрчээ. Тэгвэл “болно” гэдэг үгээр тогтоосон хэм хэмжээг илэрхийлсэн жишээ нь, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 1-д “Иргэний эрх зүйн бүрэн чадамж буюу иргэн өөрийн үйлдлээр өөртөө эрх олж авах, үүрэг бий болгох чадвар насанд хүрснээр буюу 18 наснаас **бий болно**” гэсэн байдаг.

Зөвшөөрсөн зохицуулалттай хам авч үзэх асуудал бол ардчилсан төрийн эрх зүйгээр зохицуулах журам болох “**Хуулиар хориглоогүй бүхнийг зөвшөөрнө**” гэсэн боломжийг зөв ойлгож, хэрэгжүүлэх хэрэгтэй юм.

Тухайлбал, Иргэний хуулийн 26 дугаар зүйлийн 7-д “Ашгийн төлөө хуулийн этгээд /компани, нөхөрлөл/ нь хуулиар хориглоогүй, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлаагүй аливаа үйл ажиллагаа эрхлэх эрхтэй” гэжээ. Үүнтэй холбоотойгоор төрийн байгууллага, түүний албан тушаалтанд энэ эрх эсрэгээр үйлчлэх ёстой бөгөөд “Хуулиар зөвшөөрснөөс бусдыг хориглоно” гэсэн зарчмыг баримтлах үүрэгтэй байдгийг анхаарах хэрэгтэй юм.



Хориглосон хэм хэмжээ нь эрх зүйн харилцаанд оролцогчдыг тухайн үйлдэл, үйл ажиллагааг хийх боломжийг хасах буюу хязгаарлах тухай ойлголт юм. Өөрөөр хэлбэл, шууд хориглосон буюу ихэнх тохиолдолд **“болохгүй”** эсхүл **“хориглоно”** гэсэн үгээр илэрхийлэгдэн гардаг зохицуулалт юм. Хориглосон заалтыг зөрчсөн тохиолдолд хариуцлага хүлээх нь ойлгомжтой.

Жишээ, Хориглосон хэм хэмжээ

Хөдөлмөрийн тухай хуульд “Хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулаагүй тохиолдолд ажилтнаар ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно”; Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд “Хүнсний зориулалтын бус түүхий эдээр согтууруулах ундаа үйлдвэрлэхийг хориглоно”; Иргэний хуульд “Барьцаалагч барьцааны зүйлийг худалдах болсон тухай болон худалдах үнийн тухай өмчлөгчид урьдчилан мэдэгдэх үүрэгтэй. Ийнхүү мэдэгдсэнээс хойш 14 хоногийн дотор барьцааны зүйлийг худалдаж болохгүй”; мөн хуулийн 232 дугаар зүйлийн 4-т “анзын нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 хувиас хэтэрч болохгүй” гэх мэтээр хориглосон заалтууд байдаг билээ.

“Үүргээ биелүүлэхдээ баяр хөөрийг амсч буй хүн л жинхэнэ эрх чөлөөтэй амьдарч байна”
Цецерон

Эрх зүйн харилцаанд оролцогч хэн бүхэн эрх зүйн хэм хэмжээний тогтоосон, зөвшөөрсөн, хориглосон утга агуулгыг зөв ойлгон эрхээ эдэлж, үүргээ биелүүлэх явдал чухал юм.



3. Эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хууль зүйн хариуцлага хүлээлгэдэг байна.

Эрх зүйн хэм хэмжээний хүчин чадлыг тодорхойлдог хамгийн чухал шинжийг хууль зүйн хариуцлага гэж хэлж болно. Төрөөс тогтоосон эрх зүйн хэм хэмжээ зөрчигдсөн тохиолдолд тухайн зөрчил гаргасан этгээдэд хүлээлгэх хариуцлага нь хууль зүйн дагуу байх ёстой. Өөрөөр хэлбэл, тухайн зөрчилд оногдуулах хариуцлагын төрөл, хэлбэр, хэмжээ нь хуульчлагдсан байх ойлголт бөгөөд хуульд заагдаагүй хариуцлагыг иргэнд хүлээлгэх боломжгүй байдаг.



Хууль зүйн хариуцлагын үндсэн дөрвөн төрөл байдаг. Үүнд:

- Иргэний эрх зүйн буюу эд хөрөнгийн хариуцлага;
- Эрүүгийн хариуцлага;
- Захиргааны хариуцлага;
- Сахилгын хариуцлага;



Дээрх хариуцлагын төрөл тус бүр нь өөр өөрийн хууль тогтоомжид тусгалаа олсон байдаг. Зөвхөн хуульд заасан хариуцлагыг хуулиар эрх олгогдсон албан тушаалтан, хуульд заасны дагуу хүчин төгөлдөр шийдвэрийн үндсэн дээр оногдуулдаг байна.

Төрөөс тогтоосон эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг эрх зүйн зөрчил гэнэ.

Жишээ, Хариуцлага хүлээлгэх

Хөдөлмөрийн тухай хуульд сахилгын шийтгэлийг тогтоосон байдгийг та бид мэдэх билээ. Тухайлбал, сануулах, цалинг 3 сар хүртэл хугацаагаар бууруулах, ажлаас халах шийтгэл; Эрүүгийн хуулийн 161 дүгээр зүйлд: “Хууль тогтоомжоор хориглосон, тусгай зөвшөөрөлтэйгээр явуулах үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааг дур мэдэн их хэмжээтэйгээр эрхэлсэн бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуугаас хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ”; Захиргааны хариуцлагын тухай хуулийн 30 дугаар зүйлд: “Шүүгдэгч, гэрч, хохирогч, нэхэмжлэгч, хариуцагч, шинжээч, орчуулагч болон шүүн таслах ажиллагаа хэрэгжүүлэхтэй холбогдуулан шүүхэд дуудагдсан этгээд хүрэлцэн ирэхээс зориуд зайлсхийсэн, түүнчлэн тогтоосон журам илтэд үл хүндэтгэсэн бол 5000-25000 төгрөгөөр торгох, эсхүл 7-14 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулна” гэх жишээтэй.

“Таны ямар ч алхам нийтийн хэв журамтай зохицож байхуйцаар явагтун”

Кант

4. Хууль зүйн хариуцлага нь төрийн албадлагаар хэрэгждэг байна.

Дээр үзсэн хууль зүйн хариуцлага нь заавал биелэгддэг байх ёстой. Хууль зүйн хариуцлагыг хүлээх эсэх нь гэм буруутай этгээдийн хүсэл зориг, ашиг сонирхлоос үл хамаарах шинжтэй байдаг. Хариуцлага хүлээлгэхэд төрийн албадлагыг хэрэглэдэг бөгөөд уг албадлагыг хуулиар тусгайлан эрх олгогдсон байгууллага хэрэгжүүлдэг байна. Жишээ нь, шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба.



Хариуцлага хүлээлгэхэд төрөөс албадлагыг хэрэглэнэ.

Бидний үзсэн эрх зүйн хэм хэмжээний дээрх дөрвөн үндсэн шинж нь нийгмийн харилцааг зохицуулж байгаа бусад хэм хэмжээнд байдаггүйгээрээ эрх зүйн хэм хэмжээ нь онцлог юм. Харин нийгмийн харилцааг зохицуулж байгаа эрх зүйн бус хэм хэмжээг хэрэгжүүлэх, түүнийг дагаж мөрдөх нь хувь хүний зан байдал, төлөвшил, хүсэл зориг, сонирхлоос шалтгаалж байдаг.

Орчин үед эрх зүйн зохицуулах арга нь захирамжлан албадахаас илүү хянан зохицуулах, зөвшөөрөн тохируулах шинжтэй болж байгаа нь ардчилсан төрийн шинжийг илэрхийлэхийн зэрэгцээ

нийгмийн харилцаанд оролцогчдын ухамсар, соёлын төлөв өөрчлөгдөж байгаатай холбон үзэж болно. Бид энэ хэсгээс эрх зүйн талаар өөрсдийн ойлголттой боллоо.

Бидний амьдралд хууль нөлөөлөх нь

Эрх зүйн хэм хэмжээ тогтоох замаар хууль илрэн гардаг бөгөөд төрийн хуульд бүх нийтээрээ захирагдах ёстой. Энэ нь ардчилсан төрийн үндсэн зарчмын нэг болох хууль дээдлэх ёсны тухай асуудал бөгөөд төр, түүний албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд, аж ахуйн нэгж, байгууллага бүгд хуульд захирагдан, үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд явуулах шаардлага юм.



Хууль бидний амьдралд ямар үүрэг гүйцэтгэж, ямар нөлөө үзүүлдэг талаар хүн бүр өөр өөрийн ойлголт, дүгнэлт, үзэл бодолтой байх нь мэдээж.

Хууль нийгмийн амьдралд маш олон чиг үүргийг гүйцэтгэж байдгаас бид хамгийн түгээмэл буюу голлох ач холбогдолтой дараахь үүргүүдийг авч үзье.

1. Нийгмийн харилцааны амар амгалан, тайван байдлыг хамгаална.

Энэ бол хуулийн хамгийн гол чиг үүрэг, зорилго юм. Өөрөөр хэлбэл, хууль бол нийгмийн харилцааг хэвийн, ердийн түвшинд байлгаж, тэнцвэрийг бий болгон хөгжүүлэхийг зорьдог.

Хамгаалах үүргийн үндсэн утга нь тухайн харилцаанд хүний эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсэн тохиолдолд гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэхэд оршино. Энд эрх зүйн ямар тогтолцоотойгоос үл хамааран бүх улс оронд Эрүүгийн хууль нэлээд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Бүх нийт заавал дагаж мөрдөхөөр төрөөс батлан гаргаж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон дээд хүчин чадал бүхий баримт бичгийг хууль гэнэ.

Иргэн эрхээ хамгаалуулахаар шүүхэд хандах эрхтэй.

Жишээ, Хамгаалах үүрэг

Эрүүгийн хуулийн зорилтыг авч үзье. Монгол Улсын Эрүүгийн хуулийн зорилт нь Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмч, үндэсний баялаг, байгаль орчин, эрх зүйн журам, энх тайван, хүн төрөлхтөний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалахад оршино.

Хэрвээ Эрүүгийн хууль байдаггүй бол гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял шийтгэл оногдуулж цээрлүүлэх, хохирогчийн зөрчигдсэн эрхийг хэн хамгаалж, хангах вэ? гэдэг асуултад хариулах боломжгүй болох нь мэдээж.

Одоо өөр нэгэн тохиолдлыг авч үзье. Та зээлийн гэрээний үндсэн дээр бусдад мөнгөө зээлдүүлжээ. Гэтэл таны мөнгийг гэрээний хугацаандаа төлсөнгүй. Та удаа дараа нэхээд бас л тусыг олсонгүй. Энэ үед та хэнд, хаана, хэрхэн хандах вэ? Мэдээж та шүүхэд хандаж, Иргэний хууль, Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийн дагуу шүүх таны зөрчигдсэн эрхийг сэргээн тогтоох арга хэмжээ авна.


Дээд давхрын айлаас ус алдаж таны эд хөрөнгөд хохирол учирчээ. Учруулсан хохирлоо таны шаардсанаар арилгасангүй. Та мөн л шүүхэд хандаж, шүүх дээрхи хуулиудаар эрхийг тань хамгаалах болно. Бид энэ мэтчилэнгээр өөр олон жишээг гаргаж болох бөгөөд иргэн та ч бас сонирхолтой олон жишээг гаргах нь ойлгомжтой.

2. Төрийн эрх мэдлийг тэнцвэржүүлж, хяналт тавин, иргэний эрх чөлөөг баталгаажуулна.

Хуулийн энэ үүрэгт хуулийн өмнө бүгд тэгш байх, хуульд захирагдах, хуулийг дээдлэх гэсэн зарчим шууд холбогдоно. Энэ нь төрийн хуульд иргэн нь захирагдахын хамт төр нь мөн захирагдана гэсэн үг. Өөрөөр хэлбэл, өөрийн батлан гаргасан хуульдаа төр захирагдах тухай асуудал юм.

Төр, түүний байгууллагын эрх хэмжээг хуулиар тогтоож, төрөөс иргэнтэй, иргэнээс төртэй харьцах харилцааг хуульчилдаг. Нэг үгээр хэлбэл төр иргэнийхээ өмнө, иргэн нь ч төрийнхөө өмнө үүрэг хүлээдэг байх явдал юм.

Төрийн эрх мэдэл нь нэг буюу нэг хэсэг бүлэг этгээдийн мэдэлд нэгдэж төвлөрснөөр хязгааргүй эрх мэдэл ноёлж, ардчилсан хяналт тавих боломжгүй болох бөгөөд улмаар дураар авирлах, хүний эрх, эрх чөлөөг зөрчих асуудал хэвийн үзэгдэл болох нь ойлгомжтой. Тиймээс харилцан хяналт, тэнцвэр бүхий хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн эрх мэдлийн гурван салаа мөчрийг бий болгосон байдаг нь дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн “Төрийн эрх мэдлийг хуваарилах онол”-ын дагуу тогтолцоо юм.



Жишээ, Иргэний эрхийг хамгаалах

Үндсэн хуулийн арван есдүгээр зүйлд “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэсэн байдаг.

Мөн 14 дүгээр зүйлд “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” гээд 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг заасан байна.


Хуулиар хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулна.

Үндсэн хуульд заасан эрхүүдийг хэрэгжүүлэх зорилгоор бусад салбар хуулиуд гардаг билээ.

3. Шударга өрсөлдөөнийг дэмжих замаар эдийн засгийн өсөлтийг бий болгоно.

Аливаа улс гүрний хөгжлийн суурь нь түүний эдийн засгийн хөгжлийн өсөлттэй шууд холбогддог. Өмч, эдийн засгийн харилцааг зохицуулсан олон хуулиуд байхын зэрэгцээ шударга бус өрсөлдөөнийг хориглох хууль энэ харилцаанд чухал үүрэг гүйцэтгэдэг.

Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна. Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална. Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэсэн байдаг. Энэ л зорилгоор эдийн засгийн харилцааг зохицуулсан олон тооны хуулиуд гарсаар байгаа билээ.



Иргэн бүр
хуулийн өмнө
адил, тэгш
эрхтэй байна.

4. Нийгмийн шударга ёс, тэгш байдлыг хангана.

Хууль тогтоогчийн эрхэм зорилгын нэг нь энэ бөгөөд энэ нь нийгмийн харилцаанд оролцогч сул дорой талын эрх ашгийг хуулиар хамгаалахад чиглэгддэг.

Тухайлбал, Хөдөлмөрийн хуулиар ажил олгогч, ажилтан хоёрын эрхийн тэнцвэржилтийг хангах зорилгоор тусгайлсан зохицуулалт хийдэг. Хөдөлмөрийн гэрээг талууд тохиролцож байгуулах бөгөөд ажил олгогчийн давуу байдлаа ашиглан тэгш байдлыг зөрчих боломжийг хязгаарласан заалт оруулах гэх мэт. Түүнчлэн насанд хүрээгүй хүмүүс, хүүхэд, өндөр настан, тахир дутуу иргэдийн эрхийн асуудалтай холбоотой тусгайлсан зүйл, заалттай хуулиудыг олноор нь дурдаж болно.

Эрх ашгаа хамгаалуулахаар эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх, жагсаал цуглаан хийх эрхийг хэрэгжүүлэх хууль зүйн баталгааг бий болгох нь шударга ёсыг хангах чиг үүрэгт бас хамаардаг байна.

5. Хүрээлэн буй орчныг хамгаална.


Шинжлэх ухаан, техник, технологийн асар хурдацтай хөгжлийн үед хуулийн “хүрээлэн байгаа орчныг хамгаалах” чиг үүргийн хэрэгцээ, шаардлага улам бүр нэмэгдэж байна. Энэ нь дэлхий даяар анхаарлаа хандуулдаг, тулгамдсан асуудлын нэгд тооцогдож байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд “Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэсэн байдаг. Байгаль хамгаалах, нөхөн сэргээхтэй холбоотой олон хууль тогтоомжууд манай улсад үйлчлэх бөгөөд эдгээр хуулиудаар төр, байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд эрх, үүрэг бий болгосон байдаг билээ.

Нийгмийн харилцаанд хуулийн гүйцэтгэх чиг үүргээс голлох гэснийг нь бид авч үзлээ. Хуулийн чиг үүргүүд зарим тохиолдолд хоорондоо зөрчилдөх явдал гардаг.

Тухайлбал, эдийн засгийн өсөлтийг дэмжих зохицуулалт нь хүрээлэн буй орчныг хамгаалахтай зөрчилддөг. Мэдээж энэ хоёр асуудлын аль аль нь чухал гэдэг нь ойлгомжтой.

Энэ тохиолдолд хууль тогтоогч нэг л зүйлийг удирдлага болгоно. Энэ нь дэмжих ёстой нийгмийн зорилго юунд орших ёстой вэ гэдэгт анхаарлаа илүүтэй хандуулж, зөв тэнцвэрийг баримтлах ёстой ажээ.



1.2. ХУУЛИЙН ТӨРӨЛ.

Төрөөс батлан гаргаж байгаа аливаа хууль тогтоомжийг бүх нийтээр дагаж мөрдөх ёстой. Монгол Улсын Их Хурлаас батлан гаргаж байгаа бүх хуулиуд Үндсэн хуульдаа нийцсэн байх хууль зүйн шаардлага тавигддаг.



1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан Үндсэн хуулийг “ардчилсан, шинэ” гэж бид бүхэн тодотгодог билээ. Энэ нь өмнөх Үндсэн хуулиудаас /1924 он, 1940 он, 1960 он/ зарчмын цоо шинэ өөрчлөлттэйгээр гарсантай холбоотой гэдгийг та бүхэн мэднэ. Хууль зүйн хүчин чадал, нийгмийн харилцааг зохицуулах хүрээгээр нь хууль тогтоомжийг

- Үндсэн хууль;
- Салбар хууль;
- Олон улсын гэрээ;
- Эрх зүйн бусад акт гэж ангилдаг.

Бусад бүх хуулиуд нь Үндсэн хуулиас эхтэй байж, түүнд нийцсэн байх шаардлагатай.

Үндсэн хууль

Үндсэн хуулиар нийгэм, эдийн засгийн харилцааны суурь үндэс, төрийн эрх мэдэл, хүний эрх, төр иргэний харилцаа зэргийн үндсэн суурь зарчмыг тодорхойлон тогтоож өгдөг. Үндсэн хууль нь хууль зүйн хүчин чадлын хувьд хамгийн дээд хүчин чадалтай юм. Энэ нь манай улсын бүх хууль болон бусад эрх зүйн акт нь Үндсэн хуулийг зөрчөөгүй, түүнд нийцсэн байх шаардлагатай гэсэн ойлголт юм.

Салбар хууль

Үндсэн хуулиар тунхагласан хүний эрх, эрх чөлөөг хууль зүйн хувьд баталгаатай эдлүүлэх, нийгмийн тодорхой төрлийн харилцааг нарийвчлан зохицуулах зорилгоор салбар хуулиуд гардаг. Тухайлбал, Иргэний хууль, Эрүүгийн хууль, Боловсролын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Монгол Улсын иргэнд газар

өмчлүүлэх тухай хууль, Татварын тухай хууль гэх мэтчилэн 280 гаруй хууль хүчин төгөлдөр үйлчилж байна.

Олон улсын гэрээ

Олон улсын гэрээ хуульд ямар хамаатай байх билээ гэдэг асуулт гарч болох юм. Тэгвэл дэлхий нийтээр анхаарлаа хандуулдаг, зөвшилцөн тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэх асуудлууд байдаг. Энэ нь даяарчлалын эрин үед улам бүр нэмэгдэх хандлагатай байна.

Жишээ, Монгол Улсын Үндсэн хуульд

“Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ. Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй” гэсэн байдаг. /Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйл/

Иймээс манай улсын нэгдэн орсон олон улсын гэрээ нь дотоодын хууль тогтоомжийн адил үйлчлэх ёстой бөгөөд иргэн бид бүхэн зөвхөн үндэсний хууль тогтоомжоор эрхээ хамгаалуулахаас гадна олон улсын гэрээнд заасан эрх зөрчигдлөө гэж үзвэл шүүх олон улсын гэрээний заалтын дагуу эрхийг хамгаалсан шийдвэр гаргаж болно гэсэн үг юм.

Манай улс хүний эрхийн салбар болон олон улсын эдийн засаг, худалдаа, оюуны өмч, энх тайван аюулгүй байдлын зэрэг өргөн хүрээний асуудлаар 180 гэрээнд нэгдэн орсон байдаг билээ.

Эрх зүйн бусад акт

Эрх зүйн бусад акт нь нийгмийн тодорхой төрлийн харилцааг зохицуулах чиг үүрэгтэй байдаг. Гэхдээ энэ нь хуулиар эрх олгогдсон этгээд, хамаарах асуудлынхаа хүрээнд хэм хэмжээ тогтоосон акт гаргана гэсэн үг. Жишээ нь, УИХ, Засгийн газар, Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас тогтоол; Ерөнхийлөгч, Засаг даргаас захирамж зэргийг гаргадаг. Энэ бүгд нь Үндсэн хууль болон бусад хуульд нийцсэн байх шаардлагатай нь ойлгомжтой.

Хуулийн тайлбар

Хуулийг тайлбарлах шаардлагатай юу, тэр үүргийг хэн гүйцэтгэх ёстой вэ гэсэн асуулт гарч ирнэ. Нийтэд дагаж мөрдүүлэхээр нэгэнт батлан гаргасан хууль ойлгомжтой, хэрэгжих, биелэгдэх боломжтой

байх ёстой хэдий ч хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх явцад түүнийг тайлбарлах шаардлага гарч болдог.

Хуулийн тайлбар нь үйлчлэх хүчин чадлын хувьд албан ёсны, албан ёсны бус гэж ангилагддаг. Албан ёсны тайлбарыг хуулиар эрх олгогдсон байгууллагаас гаргадаг ба Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар Улсын Дээд Шүүх тайлбар гаргахаар Үндсэн хуульд заасан. Албан ёсны тайлбарыг хууль хэрэглэж байгаа субъектүүд шууд удирдлага болгон хэрэглэх үүрэгтэй байдаг. Өөрөөр хэлбэл, шүүх болон хуулийн байгууллагууд албан ёсны тайлбарыг хуулийн нэгэн адил хэрэглэх үүрэгтэй гэсэн үг.

Монгол Улсын Дээд Шүүхийн 2003 оны 10 дугаар тогтоолоор Эрүүгийн хуулийн 35 дугаар зүйлийн зарим хэсгийг тайлбарласныг жишээгээр үзүүлье.

Жишээ; Улсын Дээд Шүүхийн тайлбарт,

Тухайлбал, “зохион байгуулагч” гэдэгт гэмт хэрэг үйлдэх явдлыг анхнаас нь сэдэж санаачлан түүнийгээ хэрэгжүүлэх бүх боломж нөхцөлийг бүрдүүлэх талаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж, удирдан чиглүүлэх ажлыг гардан хариуцаж, гэмт хэрэг үйлдэх төлөвлөгөө боловсруулах, гэмт хэрэгт оролцогчдын үүргийг хуваарилах замаар гэмт хэргийг хэдийд, хаана, хэрхэн яаж үйлдэх, гэмт хэрэг үйлдсэний дараахь ул мөрийг арилгах зэрэг асуудлыг зохицуулагч этгээд байхыг ойлгоно. Зохион байгуулагч нь гэмт хэрэг үйлдэхэд өөрийн биеэр оролцсон эсэхээс үл хамааран эрүүгийн хариуцлага хүлээлгэн” гэж тайлбарласан байна.

Албан ёсны бус тайлбар нь тухайн хуулийг хэрэглэж байгаа субъектэд заавал удирдлага болгох албан ёсны хүчин чадал агуулдаггүй ч гэсэн тэр тайлбарыг мэргэжлийн эрдэмтэд, эрдэм шинжилгээний байгууллага, судлаачдаас гаргадаг учир шинжлэх ухааны өргөн багтаамжтай, танин мэдэхүйн асар их ач холбогдолтой байдаг. Ийм учраас уг тайлбар туйлын өргөн хүрээтэй, иж бүрдэл шинжтэй байдаг. Албан бус тайлбар нь иргэдийн эрх зүйн мэдлэг, ухамсарт голлох нөлөөтэй юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн албан бус тайлбарыг гавъяат хуульч, доктор профессор Г.Совд 2000 онд гаргасан байдаг. Түүнчлэн Хөдөлмөрийн тухай хуулийн албан бус тайлбарыг доктор Б.Уранцэцэг 2002 онд гаргажээ.

Хуулийн тайлбар:

- Ø Албан ёсны
- Ø Албан ёсны бус

Á - ÈÝÃ 2. Õóóëü õýðõýí

áçòäýã âý?

2.1. Хууль санаачлах, хуулийн төсөл боловсруулах ажиллагаа


2.2. Хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах, санхүүжүүлэх

2.3. Хуулийн төслийг өргөн мэдүүлэх

Бид эхний бүлгээс хуулийн талаар тодорхой мэдлэгтэй болсон бол энэхүү бүлгээс хууль санаачлагч нь хэн байх, хуулийн төсөл гэж юу болох, түүнийг хэрхэн боловсруулдаг, хууль батлан гаргах урьдчилсан нөхцөлийн талаар үзэх болно.

2.1. ХУУЛЬ САНААЧЛАХ, ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖИЛЛАГАА

Хууль бүтэх үйл ажиллагаа нь дараах ерөнхий үе шатыг дамжин хэрэгждэг байна.



Хууль санаачлагч гэж хэн бэ?

Аливаа шинэ зүйлийг бий болгох нь түүнийг санаачлах буюу үүсгэх, эхлэлийг нь хэрхэн тавихаас эхэлдэг. Хууль өөрөө аяндаа бий болохгүй нь ойлгомжтой. Харин нийгмийн шинэ шинэ харилцааг хуулиар зохицуулах шаардлага хэрэгцээ бий болсон тохиолдолд хуулийг шинээр санаачлан боловсруулах хэрэгтэй болдог. Тэгвэл хуулийг дурын хүн санаачлах уу, эсвэл энд тусгай эрх бүхий хүн байх ёстой юу гэсэн асуулт гарч ирнэ.

Нийгмийн харилцааг зохицуулах хуулийг гаргахдаа шинээр гаргах уу, эсхүл дагаж мөрдөж байгаа хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах уу, хүчингүй болгох уу зэрэг эрхийг хэрэгжүүлэх боломжтой субъектийг “хууль санаачлагч” гэж хэлж болно. Аливаа улсын Үндсэн хуульд хууль санаачлах эрх хэнд байх тухай асуудлыг зохицуулсан байдаг.



Хууль санаачилна гэдгийг хуулийн төсөл боловсруулах ажилтай ижилтгэн үзэж болохгүй.
Г.Совд

Манай улсад Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрхтэй байна. Иймээс энэ гурван субъектийг хууль санаачлагч гэж үзнэ. Өөрөөр хэлбэл, энэ гурван субъектийн хэн нэгнээс тодорхой хууль гаргах хэрэгтэй байгаа талаар санал дэвшүүлж, тухайн хуулийнхаа төслийг мэргэжлийн түвшинд боловсруулан эцэст нь хянаж, түүнийгээ УИХ-д өргөн мэдүүлдэг байна.

Гэхдээ хууль санаачлах гэдгийг хуулийн төсөл боловсруулах ажилтай ижилтгэн үзэж болохгүй юм. Өөрөөр хэлбэл, хууль санаачлагч бүр санаачилсан хуулийн төслөө өөрөө боловсруулсан байдаггүй тул хууль санаачлах нь хуулийн төслийг УИХ-д хэлэлцүүлэхээр албан ёсоор өргөн барих эрх юм¹ гэж ойлгож болно.

Хууль санаачлах эрхээ хэрэгжүүлэхдээ хууль санаачлагчийн шийдвэрлэсэн байх асуудал

Хууль санаачлагч нь хууль санаачлах эрхээ хэрэгжүүлэхдээ дараахь асуудлыг шийдвэрлэсэн байх шаардлагатай. Үүнд:

- Нийгмийн тухайн харилцааны одоогийн төлөв байдал болон түүнийг зохицуулж байгаа хуулийн хэрэгжилт, үр нөлөөг судалсны үндсэн дээр уг асуудлаар шинээр хууль гаргах уу, эсхүл дагаж мөрдөж байгаа хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах уу гэдгийг тогтоож түүний үндэслэл, шаардлагыг тодорхойлсон байх;
- Хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлох;

¹ Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. УБ.,2000 он. 151 дэх тал

- Хуулийг хэрэгжүүлэх талаар цаашид авах арга хэмжээний тухай санал, түүнтэй холбогдон гарах төсөв, санхүүгийн зардлын тооцоог гаргасан байх;
- Монглд Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн нь санаачилж буй хуулийн төслийнхөө талаар Засгийн газар, түүнчлэн хуулийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүрэг бүхий холбогдох бусад байгууллагын санал, дүгнэлтийг авсан байх.

Иргэн, хуулийн этгээд хуулийн төсөл санаачилж болох уу?

Үүнийг зөвхөн хууль санаачлагчаар дамжуулан хэрэгжүүлэх боломжтой. Энэ асуудлыг хуулиар зохицуулсан байдаг. Тухайлбал, иргэн, хуулийн этгээд² хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид бичгээр³ уламжилна. Энэ саналыг тухайн хууль санаачлагч үндэслэлтэй гэж үзвэл тухайн асуудлаар хууль санаачилж болно. Бичгээр гэсэн хэлбэрийг хуульд тогтоосон нь биечлэн уулзаж илэрхийлэх боломжийг хаагаагүй бөгөөд гагцхүү тухайн санал таных гэдгийг тодорхойлохын зэрэгцээ цаашид үргэлжлүүлэн авч үзэх асуудал эсэхийг тогтооход бичгийн байх шаардлагыг тавьдаг байна.

Иргэд, бусад байгууллага хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид уламжилна.

Жишээ, Хууль санаачлах тухай

Энэ нь Үндсэн хуулийн 23 дугаар зүйлд “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална” 26 дугаар зүйлийн 2-т “Иргэд, бусад байгууллага хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид уламжилна” гэсэн заалттай шууд холбогдох юм.



² “Өмчлөлдөө буюу эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхдээ тусгайлсан хөрөнгөтэй, өөрийн нэрээр эрх олж, үүрэг хүлээдэг, үйл ажиллагаанаасаа бий болох үр дагаврыг эд хөрөнгөөрөө хариуцдаг, нэхэмжлэгч, хариуцагч байж чадах, тодорхой зорилго бүхий, тогтвортой үйл ажиллагаа эрхэлдэг зохион байгуулалтын нэгдлийг хуулийн этгээд гэнэ. / Монгол Улсын Иргэний хууль. 2002 он.25 дугаар зүйл/

³ “Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль”-ийн 3 дугаар зүйлийн 2.

Тухайлбал, иргэн та ямар нэгэн асуудлаар хууль гаргах, эсвэл хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хэрэгтэй байгаа тухайгаа өөрийн тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүндээ бичгээр уламжлах эрхтэй. Ингэж уламжилсан тохиолдолд тухайн гишүүн уг асуудлыг судалж, үндэслэлтэй гэж үзвэл таны анх гаргасан санаачилгын үндсэн дээр хууль санаачилж болно гэсэн үг. Энэ тохиолдолд хууль санаачлагчид уламжилж буй иргэн таны санал үндэслэлтэй, тайлбар нь оновчтой, нотолгоо, судалгаа сайтай байвал анхаарал хандуулж буй тухайн асуудлын “**үндэслэлтэй гэж үзвэл**” гэсэн нөхцөл тодорхойлогдох боломжтой билээ. Ийнхүү саналаа уламжлахдаа хуулийн төслөө өөрөө боловсруулж өгч болохын зэрэгцээ төсөл боловсруулах ажлын хэсэгт орж ажиллах саналыг тавьж болно.

Хуулийн төсөл гэж юу вэ?

“Төсөл” - энэ нь аливаа нэг бодит зүйл бий болгохын тулд урьдчилан боловсруулан гаргасан саналын цогц юм. Тэгвэл хуулийн төсөл гэж юу вэ гэдгийг “Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай” /2001 он/ хуульд “Хууль санаачлагчаас мэргэжлийн түвшинд боловсруулан, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байгаа уул төслийн эх бичвэрийг хуулийн төсөл гэнэ” хэмээн тодорхойлжээ.

УИХ-д өргөн мэдүүлж байгаа хуулийн төслийг дотор нь:

- Анхдагч хуулийн төсөл
- Хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөл
- Хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төсөл гэж ангилдаг.

Анхдагч хуулийн төсөл гэдэг нь тухайн асуудлаар урьд өмнө нь бие даасан хууль гарч байгаагүй бөгөөд санаачилсан төсөл нь “анхных” байна гэсэн үг. Жишээ нь, “Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль” төслөөрөө өргөн баригдаж байх үедээ “анхдагч” хуулийн төсөлд хамаарах юм. Өөрөөр хэлбэл, урьд өмнө нь иргэнд газар өмчлүүлэх тухай бие даасан хууль байгаагүй гэсэн үг юм.

Нэгэнт батлагдан гарсан хуулийг заавал дагаж мөрдөх шаардлагатай хэдий ч нийгмийн хөгжлийн шаардлага, хэрэгцээний улмаас түүнийг өөрчлөх, нэмэлт оруулах, хүчингүй болгох, шинэчлэн найруулах шаардлага гарч байдаг. Иймээс хуулийн төсөл гэдэгт хуулийн шинэ төслөөс гадна өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах төслүүдийг хамтад нь ойлговол зүйтэй юм.

Иргэд бид бүхэн сайн мэднэ. Шинээр хууль батлагдахаас илүү дагаж мөрдөж байгаа хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах явдал их байдаг. Энэ нь ч зайлшгүй бөгөөд хууль бол хөдөлшгүй, өөрчлөгдөшгүй баримт бичиг биш харин нийгмийн хөгжлөөр нөхцөлдөж, түүнтэй зэрэгцэн өөрчлөгдөн шинэчлэгдэж, боловсронгуй болсноор нийгмийн харилцааг зохистойгоор зохицуулах үүргээ гүйцэтгэдэг гэдгийг харуулах ёстой юм.

**ХУУЛИЙН
ТӨСӨЛ:
Хууль
санаачлагчаас
мэргэжлийн
түвшинд
боловсруулан,
Улсын Их
Хуралд өргөн
мэдүүлж
байгаа уул
төслийн эх
бичвэр.**

2.2. ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, САНХҮҮЖҮҮЛЭХ

Энэ бүлгийн эхний хэсгээс хууль санаачлагчаар хэн байх талаар бид үзлээ. Хууль санаачлагч нь хууль санаачилж байгаа тухайгаа хэнд, хэрхэн илэрхийлэх вэ? Тэгвэл энэ талаар хуулиар тогтоосон шаардлага, журам, үе шат байдаг ажээ.

Хуулийн төсөл боловсруулах ажлыг төлөвлөх

Хууль санаачлагч нь санаачлан боловсруулах хуулийн төслийнхөө талаар урьдчилан төлөвлөж, түүнийгээ **хууль боловсронгуй болгох үндсэн чиглэлд** эхлээд тусгуулах хэрэгтэй. Ингэхдээ нийгмийн тухайн харилцааг зохицуулж байгаа хуулийн хэрэгжилт, үр нөлөөг судалсны үндсэн дээр уг асуудлаар шинээр хууль гаргах болон дагаж мөрдөж буй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэлийг тодорхой заах шаардлагатай.

Үндсэн чиглэл

Хууль боловсронгуй болгох үндсэн чиглэлийн төслийг Хууль Зүй Дотоод Хэргийн Яам холбогдох бусад байгууллагын саналыг авч, нэгтгэн судалсны үндсэн дээр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн тодорхой хугацаагаар боловсруулна. Үндсэн чиглэлийн энэ төслөө Засгийн газар хуралдаанаараа хэлэлцэн УИХ-д өргөн мэдүүлнэ. УИХ хууль боловсронгуй болгох Үндсэн чиглэлийг баталдаг.

УИХ чуулганаараа хэлэлцэх хуулийн жагсаалт, дэс дарааллыг тогтоохдоо энэхүү үндсэн чиглэлийг баримталдаг. Гэсэн хэдий ч үндсэн чиглэлд тусгагдаагүй боловч зайлшгүй шаардлагатай гэж үзвэл хууль санаачлагч нь хуулийн төсөл санаачилж УИХ-д өргөн мэдүүлж болдог.

Хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах

Үндсэн чиглэлд тусгагдсан хуулийн төслийг боловсруулах ажлыг тухайн хуулийг санаачлагч хариуцан зохион байгуулдаг.

Хууль санаачлагч нь хуулийн төсөл боловсруулах ажлыг гурван хэлбэрээр зохион байгуулах боломжтой. Үүнд:

1. Хуулийн төслийг өөрөө боловсруулах;
2. Холбогдох байгууллагын шинжээч, эрдэмтэн, мэргэжлийн хүмүүсээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулах;
3. Хуулийн этгээд, иргэнээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх.

Хуулийн төсөл боловсруулах ажилд хууль санаачлагчийн эдлэх эрх

Хуулийн төсөл боловсруулахдаа хууль санаачлагч нь байгууллагын удирдлагатай нь тохиролцсоны үндсэн дээр холбогдох эрдэмтэн, мэргэжлийн хүнийг хуулийн төсөл боловсруулах ажилд татан оролцуулах, төсөл боловсруулах ажлын явцын талаар шаардлагатай гэж үзвэл олон нийтэд мэдээлэх, иргэн,

**Хууль
боловсронгуй
болгох Үндсэн
чиглэлийг
Улсын Их
Хурал
баталдаг.**

байгууллагаас ирүүлсэн хуулийн төслийн талаархи саналыг УИХ-д уламжлах, Үндсэн чиглэлд тусгуулах, өргөн мэдүүлсэн хуулийн төслөө татаж авах зэрэг бүрэн эрх эдэлнэ.

Хуулийн төсөл боловсруулах ажлыг санхүүжүүлэх

Төсөл боловсруулах үед зардал гарах уу? Мэдээж ердийн зардал гарахаас гадна тухайн асуудалтай холбоотойгоор нарийвчлан тооцоо, судалгаа хийх, олон нийтээс санал авах зэрэг олон төрлийн нэмэгдэл зардал гарч болдог.



Хууль санаачлагч нь хуулийн төсөл боловсруулахтай холбогдон гарах зардлыг өөрийн төсвөөс санхүүжүүлнэ. Харин хуулийн этгээд эсвэл иргэнээр гэрээний үндсэн дээр хуулийн төсөл боловсруулах ажлыг гүйцэтгүүлж байгаа тохиолдолд хөрөнгийн нэмэгдэл эх үүсвэр шаардагдаж болно. Энэ үед шаардагдах төсвийг төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох Санхүү, эдийн засгийн яамаар батлуулна.

Хуулийн төсөл боловсруулах ажлыг хуулийн этгээд санхүүжүүлж болох уу? Болно, гэхдээ зөвхөн ашгийн бус байгууллага⁴ санхүүжүүлэх боломжтой. Ингэж санхүүжүүлэх нь хууль тогтоох үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх зорилго агуулаагүй байхыг шаардана.

Хуулийн төсөл боловсруулах ажилд иргэн оролцох боломж

Хуулийн төсөл боловсруулах ажилд иргэн оролцох хамгийн сонгодог хэлбэр нь тухайн хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт биечлэн орж ажиллах явдал байдаг. Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг, хуулийн этгээд, иргэн хуулийн төслийг түүний үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулах шаардлагатай.

Хууль санаачлагч нь төсөл боловсруулахын өмнө түүний үзэл баримтлалыг тодорхойлсон байх хэрэгтэй. Энэхүү үзэл баримтлалыг хууль санаачлагчаас өгсөн чиглэлийн дагуу тухайн хуулийн төсөл

⁴ ашгийн байгууллагад Иргэний хуульд зааснаар компани, нөхөрлөл ордог. Иймээс компани, нөхөрлөл нь хуулийн төсөл боловсруулах ажлыг санхүүжүүлж болохгүй юм.

Иргэн оролцох хамгийн сонгодог хэлбэр нь тухайн төслийг боловсруулах ажлын хэсэгт биечлэн орж ажиллах явдал байдаг.

боловсруулах ажлын хэсэг, хуулийн этгээд, иргэн боловсруулж болно.

Хууль санаачлагч нь санаачилж байгаа хуулийн төслийнхөө талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд мэдээлсний үндсэн дээр тухайн төсөл боловсруулах ажлын хэсэгт иргэн оролцох боломжтой байх талаар нээлттэй санал тавих боломжтой юм.

Хуулийн төсөл боловсруулах явцад холбогдох мэргэжлийн байгууллага, шинжээч, их дээд сургуулийн багш, эрдэмтэн, төрийн бус байгууллага болон бусад байгууллага иргэдээс санал авч төсөл боловсруулахад харгалзан үзэж болохоор хуульд заасан байдаг.

Иймээс иргэн, хуулийн этгээд нь энэ үйл ажиллагаанд үндэслэл, судалгаа сайтай санал, хүсэлт гаргаж идэвх, санаачилгатай оролцох хэрэгтэй юм. Өөрөөр хэлбэл, энэ аргаар бид хуулийн төсөлд, түүнийг боловсруулах ажилд шууд бусаар оролцохын хамт хуулийн төсөлд өөрийн саналаа илэрхийлэх, тусгуулах боломжтой байгаа нь харагдаж байна.

Хуулийн төсөл боловсруулж байгаа ажлын хэсэг, хуулийн этгээд, иргэн нь ажлынхаа явцыг хууль санаачлагч болон түүнийг зохион байгуулж байгаа байгууллагын удирдлагад тогтмол мэдээлж, шаардлагатай зөвлөгөө авч ажилладаг байх ёстой.

Хуулийн төсөл боловсруулах ажилд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болох Хууль Зүй, Дотоод Хэргийн Яам чухал үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ хуулиар тогтоосон бүрэн эрхийг эдэлдэг.

- Ø Үндсэн чиглэлийн төсөл, төрийн байгуулалт, эрүү, иргэний зэрэг салбарын бус нийтлэг харилцааг зохицуулсан хуулийн төслийг хариуцан боловсруулах;
- Ø Засгийн газраас санаачлах хуулийн төслийн үзэл баримтлалыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;
- Ø Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүний санаачилсан хуулийн төслийн үзэл баримтлалд зөвлөмж өгөх;
- Ø Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүний санаачилсан хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль болон эрх зүйн бодлогод хэрхэн нийцэж байгаа, түүнчлэн хуулиар тогтоосон шаардлагыг хангаж байгаа эсэх талаар Засгийн газрын өгөх санал, дүгнэлтийн төслийг бэлтгэж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх;
- Ø Засгийн газраас санаачилсан хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль болон эрх зүйн бодлого болон хуулиар тогтоосон шаардлагад нийцсэн эсэхийг эцэслэн хянаж Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх буюу УИХ-д өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгох;
- Ø Төрийн захиргааны бусад төв байгууллагад хуулийн төсөл боловсруулахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;
- Ø Хуулийн төсөл боловсруулах арга зүйн асуудлаар зөвлөмж, аргачлал гаргах, хууль зүйн нэр томъёог нэг мөр болгон жигдлэх арга хэмжээ авах зэрэг бүрэн эрхийг эдэлдэг байна.


2.3. ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ӨРГӨН МЭДҮҮЛЭХ

Хуулийн төсөлд санал авах

Хуулийн төсөл боловсруулсан ажлын хэсэг, хуулийн этгээд, иргэн тухайн төслөө боловсруулж дуусмагц хууль санаачлагчид уламжилна.

Хууль санаачлагч уг төсөлд холбогдох төрийн захиргааны төв болон бусад байгууллага, мэргэжлийн шинжээч, их дээд сургуулийн багш, эрдэмтэн, төрийн бус байгууллага, иргэний саналыг авч, үндэслэлтэй гэж үзвэл төсөлд тусгаж болдог байна.

Хууль санаачлагчаас төсөлдөө санал авахдаа тодорхой нэр зааж хүргүүлэх, эсхүл уулзалт ярилцлага зохион байгуулах зэрэг аргаар санал авч болох ажээ. Төслийг хэн санаачилж байна гэдгээс хамааралтайгаар санал авах журмыг хуулиар тогтоожээ.



Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүний санаачилсан төсөлд санал авах

Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн хууль санаачилж байгаа бол төслөө Засгийн газар болон хуулийг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий холбогдох бусад байгууллагад явуулах ёстой. Энэ тохиолдолд эдгээр байгууллагууд хуулийн төслийг хэлэлцэн санал, дүгнэлтээ бичгээр өгдөг.

Засгийн газрын санаачилсан төсөлд санал авах

Засгийн газар хууль санаачилахад тухайн төсөлтэй холбогдох асуудал хариуцсан яам голлох үүргийг гүйцэтгэдэг. Боловсруулсан төсөлдөө бусад яамдын саналыг авч, үндэслэлтэй гэж үзвэл төсөлд тусгана. Төслөө сайдын зөвлөлөөр хэлэлцсэний эцэст хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хянуулахаар ирүүлнэ. Засгийн газраас санаачилсан төсөл нь шаардлагад нийцсэн эсэхийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн эцэслэн хянаж

Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх буюу УИХ-д өргөн мэдүүлэх зөвшөөрлийг бичгээр олгодог байна.

Хуулийн төсөлд иргэдээс санал авах, иргэд саналаа илэрхийлэх ямар аргууд хэрэглэгддэг вэ?

- ✓ Иргэд УИХ-д хандаж саналаа захидлаар илэрхийлэх;
- ✓ УИХ-ын үйл ажиллагааг сурталчлах төвд хандаж саналаа өгөх;
- ✓ УИХ-ын иргэдийг хүлээж авах байранд очиж саналаа өгөх;
- ✓ Өөрийн тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүнээрээ дамжуулан саналаа өгөх;
- ✓ УИХ-ын веб хуудас руу орж саналаа өгөх;
- ✓ УИХ-ын чуулганаар нээлттэй хэлэлцэх хуулийн төслийг сонин, хэвлэлд нийтлүүлж иргэдээс санал авах;
- ✓ Орон нутагт бол УИХ-ын гишүүний бие төлөөлөгчөөр дамжуулан саналаа өгөх зэрэг аргуудыг хэрэглэж болдог байна.

“Асуудлыг шийдвэрлэх нь шийдвэр зөв гаргах хамгийн их магадлал мөн”
Томас Бабингтон Маколей

Ø **Иргэд УИХ-д хандаж саналаа захидлаар илэрхийлэх.** Энэ нь хамгийн өргөн хэрэглэж болох аргын нэг бөгөөд хаяг нь Төрийн ордон, УБ-12 гэж дугуйгаа хаяглаад хандаж буй албан тушаалтныхаа албан тушаал, нэрийг нь бичнэ.

Ø **УИХ-ын үйл ажиллагааг сурталчлах төвд хандаж саналаа өгөх.**

УИХ-ын талаархи иргэдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, УИХ-ын үйл ажиллагааг олон нийтэд илүү нээлттэй болгох, хууль тогтоох болон хяналтын үйл ажиллагаанд иргэд, төрийн бус байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх үүднээс УИХ-ын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах танхимуудыг “Ардчилсан засаглалын парламентийг бэхжүүлэх” төслийн хүрээнд ажиллуулж байна. Орон нутагт: Архангай, Баян-Өлгий, Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Орхон, Өмнөговь, Увс, Ховд аймагт; Нийслэлд: Сүхбаатар, Чингэлтэй, Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол дүүрэгт тус тус ажиллаж байна.

Сурталчилгааны төвүүд аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газрын байранд ажилладаг.

УИХ-ын үйл ажиллагааны сурталчилгааны танхим нь дараахь үүргийг гүйцэтгэдэг байна. Үүнд:

1. УИХ-аас батлан гаргасан хууль, бусад шийдвэрийг олон нийтэд сурталчлах, УИХ-аар хэлэлцэх хуулийн төслийг танилцуулах, төсөлтэй холбоотой санал, хүсэлтийг иргэдээс авах, УИХ-д нэгтгэж ирүүлэх;

2. Иргэд, сонгогчидтой хийх уулзалт, ярилцлагын байр танхимыг бэлтгэх, техник хэрэгслээр үйлчлэх;

3. УИХ-ын гишүүдийн үйл ажиллагааг сурталчлах;

4. Төв болон орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах зэрэг үүргийг гүйцэтгэдэг.

Танхим нь дээрх үйл ажиллагааг явуулахдаа УИХ-ын гишүүдийн бие төлөөлөгч болон туслахуудтай хамтарч ажилладаг байна.

Харилцах утас: УИХ-ын Тамгын газрын Захиргаа, олон нийттэй харилцах хэлтэс. 261377, 264834

Ø УИХ-ын иргэдийг хүлээж авах байранд очиж саналаа өгөх

УИХ-ын Тамгын газар

Даваа	9.00-13.00	14.00-17.30
Мягмар	9.00-13.00	14.00-17.30
Лхагва	9.00-13.00	14.00-17.30
Пүрэв		14.00-17.30
Баасан	9.00-13.00	14.00-17.30

Засгийн газрын хэрэг эрхлэх газар

Даваа гаригт:	9.00-13.00	14.00-17.30
Мягмар	9.00-13.00	
Лхагва	9.00-13.00	14.00-17.30
Пүрэв	9.00-13.00	14.00-17.30
Баасан	9.00-13.00	

Ерөнхийлөгчийн тамгын газар

Даваа	10.00-12.30	
Мягмар	10.00-12.30	
Лхагва	10.00-12.30	
Пүрэв		14.00-17.00
Баасан	10.00-12.00	

Ø Өөрийн тойргоос сонгогдсон УИХ-ын гишүүнээрээ дамжуулан саналаа өгөх

УИХ-ын гишүүд иргэдийг Төрийн ордон дахь уулзалтын өрөөнд тэдний хүсэлтийн дагуу хүлээн авч уулздаг бөгөөд уг ажлыг УИХ-ын иргэдийг хүлээн авах ажлыг хариуцсан зохион байгуулагч болон олон нийттэй харилцах асуудал хариуцсан зохион байгуулагчид тус тус хариуцан зохион байгуулна. Тухайн УИХ-ын гишүүнтэй холбоо барьж цагийг товлон урьдчилан мэдэгдэх бөгөөд дараахь цагуудад уулзалтыг зохион байгуулна.

Даваа	9.30-13.00	14.00-17.00
Мягмар	9.30-13.00	14.00-17.00
Лхагва	9.30-13.00	14.00-17.00
Пүрэв	11.00-11.20	14.00-15.00
Баасан	11.00-11.20	14.00-15.00

УИХ-ын гишүүн биечлэн уулзах боломжгүй тохиолдолд гишүүний орон тооны ажилтан нь уг иргэнийг хүлээн авч санал, хүсэлтийг нь гишүүндээ уламжилж болно.

УИХ-ын гишүүдийн уулзалтын өрөө нь Төрийн ордны баруун жигүүрийн 1 дүгээр давхарт 149 тоот, баруун хойд хаалганы дэргэд байна.

Ø УИХ-ын веб хуудас руу орж саналаа өгөх

Дараахь вэб хуудас руу орж саналаа өгөх боломжтой.

www.parl.gov.mn

www.open-government.mn

www.forum.mn

www.pmis.gov.mn

Жич: Яамдын веб хуудасны хаяг, УИХ-ын Тамгын газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Ерөнхийлөгчийн тамгын газрын зарим албадын хаяг, харилцах утсыг энэхүү гарын авлагын төгсгөлд хавсаргалаа.

“Үйлс хэдий
өчүүхэн
боловч эс
үүсгэвээс үл
бүтмэй”
В.Инжинаш

Ø УИХ-ын чуулганаар нээлттэй хэлэлцэх хуулийн төслийг сонин, хэвлэлд нийтлүүлж иргэдээс санал авах үед саналаа өгөх

Санал өгөх энэ арга нь иргэдийн оролцооны идэвхтэй байдлыг нэлээд шаарддаг бөгөөд нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулж байгаа байгууллага, албан тушаалтанд хаяглан санал, хүсэлтээ өгнө. Дийлэнхи тохиолдолд энэ үйл ажиллагааг УИХ-ын Тамгын газар хариуцан зохион байгуулах бөгөөд хаяг нь Төрийн ордон. УБ-12.

Энд нээлттэй номын сангууд чухал үүрэг гүйцэтгэх учиртай.

Олон нийтийн нээлттэй номын сан:

1. “Монголын нээлттэй нийгэм буюу Соросын сан”-ийн Боловсролын номын сан. Хаяг: Соёлын төв өргөө, Уран зургийн Галлерейн хажуугийн арканд.

2. Хууль зүйн үндэсний төвийн Хууль зүйн мэдээллийн төвийн номын сан. Хаяг: Үндэсний архивын байр. 206 тоот

Монгол Улсын хууль, хууль тогтоомжийн эмхтгэлийг албан ёсоор нийтлэх эрх авсан байгууллагууд:

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар 2002 онд тендер зарлаж, нийт гурван байгууллагад Монгол Улсын хууль, хууль тогтоомжийн эмхтгэл /Төрийн мэдээлэл сэтгүүлээс бусад/-ийг албан ёсоор нийтлэх эрхийг 3 жилийн хугацаагаар олгожээ. Уг хугацаа 2005 онд дуусна. Албан ёсоор нийтлэх эрх бүхий байгууллагад:

1. Хууль зүйн үндэсний төв
2. “Интерпресс” ХХК
3. “Зууны мэдээ” сонин

Иймээс иргэд бид дээрх аргуудаас аль боломжит буюу өөрийн хүссэн аргаараа хуулийн төсөлд саналаа өгөх нь зүйтэй юм.

Хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх⁵


Иргэн хуулийн төсөлд саналаа өгөх нээлттэй, боломжтой хэлбэр нь төслийг ард нийтээр хэлэлцүүлэх үед идэвхтэй оролцох явдал юм. Шаардлагатай гэж үзвэл хууль санаачлагч нь нийгмийн нэн чухал харилцааг зохицуулахаар санаачилсан хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх тухай саналаа УИХ-д оруулж болно гэж хуульд заажээ. Иймээс иргэд бид тухайн хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх шаардлага байгаа тохиолдолд энэ талаар санал, хүсэлтээ өөрийн сонгосон гишүүндээ уламжилж байх хэрэгтэй юм.

Хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх тухай оруулсан саналыг УИХ чуулганаараа хэлэлцэж, гишүүдийн дийлэнхи олонхийн (2/3) саналаар шийдвэрлэнэ.

⁵ Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль. 2001 он. 19 дүгээр зүйл.

“Анхад нь
болгоомжлон
бод
Дунд нь
шинжилж оно
Эцэст нь
зохилдуулан
тавь”

Ноён хутагт
Дулдуйтын
Данзанравжаа



Хуулийн төслийг ард
нийтээр хэлэлцүүлэх

Хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэхдээ тухайн асуудлаас хамаарч дараахь хүрээнд хэлэлцүүлж болно. Үүнд:

- Ø Нийт ард түмнээр;
- Ø Нийгмийн тодорхой бүлэг, ажил мэргэжлийн хүрээнд;
- Ø Тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд.

Хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх тухай УИХ шийдвэр гаргавал энэ ажлыг Засгийн газар зохион байгуулна. Үүний зэрэгцээ ард нийтээр хэлэлцүүлсэн дүнг нэгтгэн УИХ-ын чуулганаар уг хуулийн төслийг хэлэлцэхэд танилцуулах үүрэгтэй.

Хуулийн төслийн ард нийтийн хэлэлцүүлэг

Хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлсэний нэг жишээ нь 1992 оны Үндсэн хууль юм. 1991 оны 6 дугаар сарын 10-ны өдрөөс 9 дүгээр сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд Үндсэн хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлж байсан ба уншигч та ч бас энэ хэлэлцүүлэгт орж байсан болов уу.

1992 оны Үндсэн хууль, 1991 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр батлагдсан Хөдөлмөрийн хуулийн төслийг дараахь газруудаар хэлэлцүүлсэн байна. Үүнд:

1. Нийтийн үйлчилгээний газар
2. Албан газар
3. Хөдөлмөрийн хамт олон
4. Яам, улсын хороо, тусгай газар
5. Яамны шууд харъяа газар
6. Хоршооллын төв газар

Хуулийн төслийг өргөн мэдүүлэх

Ингээд бидний дээр үзсэнээр хуулийн төслийг боловсруулж дуусаад, түүндээ санал аваад эцэслэн боллоо гэж үзвэл төслөө УИХ-д өргөн мэдүүлэх гэсэн үе шат үлдэж байна. Хууль санаачлагч төслөө УИХ-ын даргад өргөн мэдүүлдэг. Үүний өмнө төслийг холбогдох баримт бичгийн хамт УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргад ирүүлнэ. Ерөнхий нарийн бичгийн дарга 72 цагийн дотор хуулийн төсөл, холбогдох бичиг баримтыг хянаж, УИХ-ын даргад өргөн мэдүүлэх хугацааг товлон хууль санаачлагчид мэдэгддэг ажээ.

“Бусармаг
явдлыг
хараад
дуугүй байна
гэдэг өөрөө
түүнд
оролцож
байна гэсэн
үг”

Жан Жак
Руссо

А - ӨҮҮ 3. Өөөөөөөө өөөөөөөө өөөөөөөөөөөө

3.1. Хуулийн төсөл хэлэлцэх, батлах үе шат

3.2. Хуулийн төслийг Байнгын хороогоор урьдчилан хэлэлцэх

3.3. Хуулийн төслийг УИХ-аар хэлэлцэх

3.4. Хуулийг ёсчлох, нийтлэх, мэдээлэх

Бид өмнөх бүлгээс хууль санаачлагч хэн байх, хуулийн төсөл, түүнийг боловсруулах, төслийг УИХ-д хэрхэн өргөн мэдүүлдэг тухай мэддэг болсон. Тэгвэл энэ бүлгээс бид хуулийн төслийн хэлэлцэж батлах үе шат, хууль хүчин төгөлдөр болох, Ерөнхийлөгчийн хуульд хориг тавих эрх, энэхүү хоригийг хүлээн авах эсэх тухайг шийдвэрлэх журам, хуулийг ёсчлох, хэрхэн нийтлэх тухай мэдлэгийг олж авах болно.

3.1 ХУУЛИЙН ТӨСӨЛ ХЭЛЭЛЦЭХ, БАТЛАХ ҮЕ ШАТ

Бид УИХ-д өргөн мэдүүлэх хуулийн төслийг УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга хүлээн авч, 72 цагийн дотор хуулийн төсөл, түүнд холбогдох бичиг баримтыг хянаад, УИХ-ын даргад өргөн мэдүүлэх хугацааг товлон хууль санаачлагчид мэдэгддэг тухай өмнөх бүлгээс мэдсэн билээ. Ингээд товлосон хугацаанд хууль санаачлагч санаачилсан хуулийн төслөө УИХ-ын даргад өргөн мэдүүлдэг байна. Хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хуулийн төслийг УИХ-ын дарга төслийн агуулгыг үндэслэн тухайн асуудлыг эрхэлсэн Байнгын хороонд¹ шилжүүлдэг.

Төсөл хэлэлцэх, батлах үе шатыг үзье.

Нэгдүгээр үе шат:

- 1. нам, эвслийн бүлэг, зохих Байнгын хорооны хуралдаанаар төслийг УИХ-ын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх эсэх тухай дүгнэлт гаргах*
- 2. УИХ-ын нэгдсэн хуралдаанаар төслийг хэлэлцэх эсэх тухай санал хураалт явуулах*

Хоёрдугаар үе шат:

- 1. нам, эвслийн бүлэг, Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэж дүгнэлт гаргах*
- 2. УИХ-ын нэгдсэн хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлэг явуулах*

Гуравдугаар үе шат:

- 1. анхны хэлэлцүүлгээр шийдвэрлэсэн асуудлыг тусгаж төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх*
- 2. УИХ-ын нэгдсэн хуралдаанаар төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулах*
- 3. төслийг батлах*

Дөрөвдүгээр үе шат:

- 1. эцсийн хэлэлцүүлгээр шийдвэрлэсэн асуудлыг тусгаж хууль, тогтоолын эцсийн найруулгыг бэлтгэх*
- 2. УИХ-ын нэгдсэн хуралдаанаар хууль, тогтоолын эцсийн найруулгатай танилцах*
- 3. шийдвэрийг ёсчлох*
- 4. Ерөнхийлөгч УИХ-ын шийдвэрт хориг тавьсан бол тухайн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх*

¹ УИХ-ын Байнгын хороо нь УИХ-ын үйл ажиллагааны зохион байгуулалтын хэлбэр юм. Байнгын хороо нь УИХ-ын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал боловсруулах, урьдчилан хэлэлцэж дүгнэлт гаргах, түүнчлэн эрхлэх асуудлынхаа хүрээнд УИХ-ын хяналтыг хэрэгжүүлэх нийтлэг чиг үүрэгтэй.

3.2 ХУУЛИЙН ТӨСЛИЙГ БАЙНГЫН ХОРООГООР ХЭЛЭЛЦЭХ

УИХ-ын Байнгын хороо

УИХ-аас Байнгын хороог үйл ажиллагааныхаа салбар, чиглэлээр байгуулдаг. Байнгын хорооны бүрэлдэхүүнд УИХ-ын гишүүд ордог бөгөөд дараахь хороодтой байна. Үүнд:

- ✓ Аюулгүй байдал, гадаад бодлогын;
- ✓ Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн;
- ✓ Нийгмийн бодлогын;
- ✓ Төрийн байгуулалтын;
- ✓ Төсвийн;
- ✓ Хууль зүйн;
- ✓ Эдийн засгийн;

Байнгын хороо нь хуулиар тогтоосон нийтлэг бүрэн эрх, өөр өөрийн эрхлэх асуудалтай байдаг. Үүний нэг нь УИХ-д өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар дүгнэлт гаргах эрх юм. Энэхүү дүгнэлтийг гаргахдаа туслалцаа авах, мэргэжлийн байгууллага болон олон нийтээс санал авах зорилгоор шинжээч, мэргэжилтнээс бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажиллуулах бололцоотой байдаг байна.

Байнгын хорооны ажлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан юм. Эрх хэмжээнийхээ асуудлыг хуралдаанаар хэлэлцэж, оролцсон гишүүдийн олонхийн санал²аар шийдвэрлэдэг.

Байнгын хороогоор төслийг хэлэлцэх

УИХ-д өргөн мэдүүлсэн хуулийн төслийг УИХ-ын дарга холбогдох Байнгын хороонд хүлээлгэн өгдөг. Байнгын хороо хүлээн авсан хуулийн төслийг хуралдаанаараа хэлэлцэх бөгөөд УИХ-ын гишүүн харьяалагдах Байнгын хорооны хуралд таслах эрхтэй, бусад Байнгын хорооны гишүүн хуралд таслах эрхгүй оролцдог.

Байнгын хорооны хуралдаанд УИХ-ын гишүүн санал, дүгнэлт гаргах, саналаа хураалгах, тухайн асуудлаар цөөнх болж зарчмын зөрүүтэй саналаа Байнгын хорооны дүгнэлтэд тусгуулах эрхтэй байдаг байна.

Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх явцад төслийн талаар хууль санаачлагчид асуулт тавьж, хариулт авч болдог. Хэрвээ хэлэлцүүлж байгаа уг хуулийн төсөл батлагдсанаар тухайн санхүүгийн жилийн улсын төсвийн зарлагын хэмжээ нэмэгдэхээр байвал энэ тухай Засгийн газрын санал, дүгнэлтийг заавал сонсох ёстой байдаг. Энэ нь хуулийг хэрэгжүүлэх явдлыг бодитой болгохтой холбоотой юм.

Байнгын хороогоор хэлэлцүүлсэн хуулийн төслийн талаар бусад Байнгын хорооны гишүүнээс гаргасан саналыг төсөл хэлэлцүүлсэн Байнгын хороо дүгнэлтдээ тусгана. Ерөнхийлөгч төсөлтэй

Байнгын хорооны ажлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан юм.

² Олонхийн буюу ердийн олонхийн санал гэдэг нь хуралдаанд оролцогчдын 1/2 гэсэн буюу 50 хувиас дээшхи, харин дийлэнхи олонхи гэдэг нь 2/3 гэсэн ойлголт юм.

холбогдуулан бичгээр санал ирүүлсэн тохиолдолд Байнгын хорооны хуралдаанд заавал танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанд түүний гишүүн биечлэн оролцох ёстой байдаг хэдий ч биечлэн оролцох боломжгүй бол уг гишүүн санал дүгнэлтээ урьдчилан бичгээр гаргаж Байнгын хороондоо өгсөн байх шаардлагатай. Энэ тохиолдолд тэр санал дүгнэлтийг хуралдаанд заавал танилцуулж хэлэлцүүлдэг ёстой.

Байнгын хорооноос хуулийн төслийн талаар дүгнэлт гаргах

Байнгын хорооноос хуулийн төсөлтэй холбогдуулан хоёр шаттай дүгнэлт гаргана. Байнгын хорооны хуралдаанаар УИХ-д өргөн мэдүүлсэн төслийн талаар санал хураалт явуулсны үндсэн дээр уг төслийг УИХ-ын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх шаардлагатай эсэх талаар дүгнэлт гаргана. Ингээд энэ дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнийг томилно.

Төслийг УИХ-ын нэгдсэн хуралдаанд хэлэлцэхээр шийдвэрлэвэл уг төслийг Байнгын хороо анхны хэлэлцүүлэгт бэлтгэн, төслийн талаар дүгнэлт гаргана. Тэгээд түүнийг нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнийг томилно.

Энэ хоёр дүгнэлтийг хамтатган гаргаж болно. Өргөн мэдүүлсэн хуулийн төслийг шаардлагатай гэж үзвэл Байнгын хороодын хамтарсан хуралдаанаар хэлэлцэж нэгдсэн дүгнэлт гаргаж болдог.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх явцад хууль санаачлагчийн зөвшөөрөлгүйгээр төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулахыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг /2001 он/-ийн 22.9-т хориглосон байдаг. Эндээс Байнгын хороо зөвхөн дүгнэлт гаргах үүрэгтэй л оролцох ёстой нь ойлгогдох юм.

Харин хууль санаачлагч хийгээд төслийг хэлэлцэж байгаа Байнгын хороо, бусад Байнгын хороо зарчмын зөрүүтэй саналаараа зөвшилцөлд хүрэхийн тулд шинжээч томилон дүгнэлт гаргуулах, Засгийн газрын холбогдох гишүүний болон бусад албан тушаалтны саналыг сонсох зэргээр ажиллаж болно.

Хэрэв нэг асуудлаар хоёр буюу түүнээс дээш төсөл байгаа бол төсөл санаачлагчийн зөвшөөрлөөр зохих Байнгын хороо тэдгээрийг нэгтгэн зохицуулж, нэг төсөл болгон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж болно. Хэрвээ төсөл санаачлагч ингэж нэгтгэхийг зөвшөөрөөгүй бол Байнгын хороо тус тусад нь дүгнэлт гаргана.

Хуулийн төсөлд олон нийтээс санал авах

УИХ-ын нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх эсэх тухай асуудлыг шийдвэрлэхдээ шаардлагатай гэж үзвэл анхны хэлэлцүүлэг явуулахаас өмнө уг төслийг өдөр тутмын хэвлэлд нийтлүүлж, олон нийтээс санал авч болдог байна.

Олон нийтээс ирүүлсэн саналыг судалж үзсэний үндсэн дээр зохих Байнгын хороо нь шаардлагатай гэж үзвэл хуулийн төсөлд санал өгсөн иргэн эсхүл хуулийн этгээдийн төлөөлөгчийг Байнгын хорооны хуралдаанд урьж ирүүлэн, тухайн саналын талаар асуулт тавьж, хариулт авч болдог байна.



Олон нийтээс санал авах ажлыг төсөл хэлэлцсэн Байнгын хороо, УИХ-ын Тамгын газар хамтран зохион байгуулах юм. Өөрөөр хэлбэл, хуулийн төслийг хэвлэлд нийтлүүлэх, санал авах, ирсэн саналыг нэгтгэх, судлах ажлыг хариуцан зохион байгуулах явдал юм.

Хуулийн төслийг өдөр тутмын хэвлэлд нийтлэхдээ иргэд, байгууллагаас санал ирүүлэх хугацаа, саналыг хүлээн авах Байнгын хорооны нэрийг заасан байна.

Олон нийтээс ирүүлсэн саналыг судалж үзсэний үндсэн дээр зохих Байнгын хороо нь шаардлагатай гэж үзвэл хуулийн төсөлд санал өгсөн иргэн эсхүл хуулийн этгээдийн төлөөлөгчийг Байнгын хорооны хуралдаанд урьж ирүүлэн, тухайн саналын талаар асуулт тавьж, хариулт авч болдог байна. Иргэн та ийм үйл ажиллагаанд оролцох боломж байсан эсэх, мөн ийм боломж хэр зэрэг байгаа талаар өөр өөрийн бодолтой байгаа биз ээ.

Харин төсөлд санал авахтай холбогдон гарах зардлыг УИХ-ын жил бүрийн төсөвт тусгахаар хуульчилсан байдаг.

Хуулийн төслийг өдөр тутмын хэвлэлд нийтлэхдээ иргэд, байгууллагаас санал ирүүлэх хугацаа, саналыг хүлээн авах Байнгын хорооны нэрийг заасан байна.

3.3 ХУУЛИЙН ТӨСЛИЙГ УИХ-аар ХЭЛЭЛЦЭХ

Улсын Их Хурал хууль санаачлагчаас өргөн мэдүүлж, чуулганы хуралдаанаар хэлэлцэхээр шийдвэрлэж, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулан баталсан төслийг хэлэлцэнэ.

Хэрвээ чуулганы хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд ороогүй төслийг УИХ-аар хэлэлцүүлэхээр тухайн чуулганы явцад өргөн мэдүүлбэл Төрийн байгуулалтын Байнгын хороо, тухайн асуудлыг хамаарах Байнгын хорооны дүгнэлтийг харгалзан түүнийг чуулганаар хэлэлцэх эсэхийг УИХ-ын нэгдсэн хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэдэг байна.



УИХ-д өргөн мэдүүлсэн төслийг чуулганы хуралдаанаар хэлэлцэх, эсхүл буцаах асуудлыг шийдвэрлэхдээ:

- Ø Төслийн талаар хууль санаачлагчийн илтгэлийг сонсох. Энэхүү илтгэлтэй холбогдуулан УИХ-ын гишүүд асуулт тавьж, хариулт авах
- Ø Төслийн талаар Байнгын хороо, нам, эвслийн бүлгийн дүгнэлтийг сонсох
- Ø Төслийг УИХ-ын чуулганы хуралдаанаар хэлэлцэх эсэх талаар санал хураалт явуулах үе шатыг дамждаг.

Санал хураалтын дүнд төслийг УИХ-ын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх шаардлагагүй гэж үзвэл тухайн төслийг буцаах тогтоол гаргана. Ингэхдээ уг тогтоолд төслийг буцаах болсон үндэслэлийг заах шаардлага тавигддаг.

Одоо УИХ-ын нэгдсэн хуралдаанаар төслийн анхны хэлэлцүүлэг явуулахад ямар журам баримталдаг талаар товч үзье.

Улсын Их Хурлын хуралдааны ажиллагаа нь хууль дээдлэх, асуудлыг чөлөөтэй хэлэлцэх, цөөнхийн санаа бодлыг хүндэтгэж олонхийн саналаар шийдвэрлэх зарчимд үндэслэнэ.

Ø Байнгын хорооны дүгнэлтийг сонсох

Хуулийн төслийг хариуцан хэлэлцэж, дүгнэлт гаргасан Байнгын хороо өөрийн дүгнэлтийг УИХ-ын нэгдсэн хуралдаанд танилцуулдаг. Ингэж танилцуулах хугацаа 15 минутаас илүүгүй байна. Энэхүү дүгнэлтэд уг төслийн үзэл баримтлал төрийн бодлогод нийцэж байгаа эсэх, төсөл хууль тогтоомжийн бичлэгийн техник, хэл зүйн шаардлагыг хангасан эсэх болон төслийн зүйл, заалтын талаар зарчмын өөр саналтай бол үндэслэл, шалтгааныг заасан байх шаардлага тавигдана.

Энэ Байнгын хороо төсөлд оруулах нэмэлт, өөрчлөлт болон Улсын Их Хурлын гишүүний зарчмын зөрүүтэй саналыг томъёолж бүх гишүүдэд урьдчилан тараасан байх хэрэгтэй.

Ø Нам, эвслийн бүлгийн дүгнэлтийг сонсох

Байнгын хорооны дүгнэлтийн дараа Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн дүгнэлтийг сонсоно. Дүгнэлтийг бүлгийн ахлагч, эсхүл тухайн асуудлыг хариуцаж байгаа бүлгийн аль нэг гишүүн танилцуулна.

Нам, эвслийн бүлгийн дүгнэлтийг танилцуулах хугацаа тус бүр 10 минутаас илүүгүй байхаар тогтоодог.

Ø УИХ-ын гишүүн үг хэлэх, тайлбар хийх

Улсын Их Хурлын гишүүн хэлэлцэж байгаа асуудлаар үг хэлэх, тайлбар хийхдээ 5 минутаас илүүгүй байхаар хугацааг баримтлах бөгөөд санал, дүгнэлтээ Байнгын хорооны болон нам, эвслийн бүлгийн дүгнэлтэд тусгуулж урьдчилан тараасан байна.



Зарчмын зөрүүтэй санал

Хэлэлцүүлгийн явцад зарчмын зөрүүтэй санал дээр илүүтэй их анхаарал хандуулдаг байна. Төслийн талаар гарсан зарчмын зөрүүтэй санал гэдэгт дараахь саналуудыг ойлгоно.

Хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад зарчмын зөрүүтэй санал дээр илүүтэй их анхаарал хандуулдаг.

а/ Байнгын хорооноос санал нэгтэй буюу олонхийн саналаар оруулахаар шийдвэрлэсэн төсөлд урьд нь тусгагдаагүй байсан санал;

б/ Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэж, зөвшилцөлд хүрээгүй Улсын Их Хурлын гишүүний санал;

в/ Улсын Их Хурал дахь олонхи, цөөнхийн нам, эвслийн бүлгээс зарчмын гэж үзэж дүгнэлтдээ тусгасан саналыг тус тус ойлгоно.

Зарчмын зөрүүтэй санал гаргасан гишүүд уг саналынхаа талаар тайлбар хэлж болох бөгөөд түүнийг дэмжсэн болон эсрэг саналтай тус бүр нэг гишүүн үг хэлж болно гэж дэгээр³ тогтоосон байдаг. Зарчмын зөрүүтэй саналтай Улсын Их Хурлын гишүүн Байнгын хорооны дүгнэлтэд тусгуулсан саналаа бичгээр гаргаж /томъёолж/ урьдчилан өгсөн байна. Харин найруулгын чанартай засварыг ажлын хэсэгт өгдөг ажээ.

Зарчмын зөрүүтэй асуудал дээр санал хураах

Зарчмын зөрүүтэй санал гарсан үед хуралдаан даргалагч асуудал /санал/ тус бүрээр санал хурааж шийднэ. Ингэхдээ гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэдэг байна.

Хэрэв Ерөнхийлөгч хэлэлцэж байгаа төсөлтэй холбогдуулан Улсын Их Хуралд илгээлт, санал ирүүлсэн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүдэд урьдчилан тарааж танилцуулсан байна. Ерөнхийлөгчийн саналыг санал хураалт явуулах замаар шийдвэрлэнэ.

Хуралдаан даргалагч зарчмын зөрүүтэй асуудлаар санал хураалгахдаа санал хураах цагийг тогтоож, нийт гишүүдэд зарлаж болно. Хэрэв санал хураах цагийг товлон зарласан бол Улсын Их Хурлын гишүүн өөрийн биеэр хүрэлцэн ирж санал хураалтад оролцох ёстой ажээ.

Зарчмын зөрүүтэй асуудлаар санал хураасны эцэст дараахь шийдвэрийн аль нэгийг санал хурааж шийдвэрлэнэ:

а/ төслийг бүхэлд нь эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх;

б/ төслийг хууль санаачлагчид буцаах. Энэ тохиолдолд Улсын Их Хурал төслийг хууль санаачлагчид буцаах тогтоол батална.

Ø Төслийг эцсийн хэлэлцүүлэгт шилжүүлэх

Анхны хэлэлцүүлгийн явцад төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гараагүй түүнчлэн уг төслийг батлах санал гарсан бол түүний эцсийн хэлэлцүүлгийг шууд явуулж болдог.

³ УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн 23.5.3. 2001 он

**“Үйлс хэдий
өчүүхэн
боловч эс
үүсгэвээс үл
бүтмэй”**

В.Инжинаш

Улсын Их Хурал төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороонд шилжүүлэхдээ дэмжигдсэн саналын дагуу төслийг зарчмын хувьд өөрчлөх, найруулах үүрэг бүхий Улсын Их Хурлын болон хууль санаачлагчийн хамтарсан ажлын хэсэг байгуулж болно.

Харин төслийг эцсийн хэлэлцүүлэгт оруулах хугацааг хэн тогтоох вэ? Тухайн төсөлтэй холбоотой нэмж боловсруулах ажлын хэмжээ, шаардлагыг харгалзан хуралдаан даргалагч энэ хугацааг тогтоодог байна.

Анхны хэлэлцүүлгээр шийдвэрлэсэн асуудлыг төсөлд тусгаж эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын үе шат

- ✓ төслийг хууль санаачлагч, Байнгын хороо хариуцаж ажлын хэсэгт эцэслэн боловсруулна;
- ✓ төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэн дүгнэлт гаргасан зохих Байнгын хороо анхны хэлэлцүүлгээр шийдвэрлэсэн байдлыг үндэслэн Улсын Их Хурлын гишүүний болон хууль санаачлагчийн томъёолж өгсөн санал бүрийг хянан үзэж төсөлд зохих нэмэлт, өөрчлөлт оруулж, хууль тогтоомжийн бичлэгийн техник, хэл зүй, найруулгын талаас нь нягтлан зохих танилцуулга бэлтгэнэ.

Ерөнхийлөгч тухайн төслийн анхны хэлэлцүүлгээр шийдвэрлэсэн асуудалтай холбогдуулан саналаа бичгээр ирүүлж болдог. Энэ тухай Байнгын хороо хэлэлцэж, танилцуулгадаа тусгана.

Төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулахад баримтлах журам

- ✓ төслийн талаар Байнгын хорооны танилцуулга хийх хугацаа 10 минутаас илүүгүй байна;
- ✓ Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт, хариулт явуулж болно;

Эцсийн хэлэлцүүлгийн явцад санал хураах асуудал

а/ эхний хэлэлцүүлгийн үед гүйцээн боловсруулахаар шийдвэрлэсэн төслийн зүйл, заалт байгаа бол;

б/ эхний хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн боловч уг асуудлаар дахин санал хураах шаардлагатай гэсэн Байнгын хорооны саналыг чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны нэг нь дэмжсэн бол;

в/ төслийн аль нэг зүйл, заалт хүчин төгөлдөр дагаж мөрдөж байгаа хууль болон уг төслийн бусад зүйл, заалттай зөрчилдөж байна гэж Байнгын хороо болон Хууль зүйн байнгын хороо үзсэн бол дээрх асуудал тус бүрээр санал хурааж шийдвэрлэнэ.

Харин санал хураалгахын өмнө тухайн саналыг гаргасан Улсын Их Хурлын гишүүн, тайлбар өгөх буюу үг хэлж болно. Тайлбар өгч, үг

“Эрхийн хамгийн эвлэршгүй дайсан бол тусгай эрх ямба юм”

М.Эбнер-Эшенбах

хэлсэн хүмүүстэй ижил тооны гишүүд хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр энэ саналынх нь эсрэг үг хэлж болно.


Төслийг батлах

Эцсийн хэлэлцүүлэг дууссаны дараа төслийг бүхэлд нь батална. Төслийг бүхэлд нь батлах санал хураалтын цагийг хуралдаан даргалагч товлон зарлаж болно.

Хэрэв төслийг бүхэлд нь батлаагүй бол төслийг хууль санаачлагчид буцаана. Шаардлагатай гэж үзвэл эцсийн хэлэлцүүлгээр батлагдсан хуультай холбогдох тогтоолын төслийг хэлэлцэн батална.

Эцсийн хэлэлцүүлгээр баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг хэлэлцүүлэг дууссанаас хойш ажлын 6 өдөрт багтаан Улсын Их Хуралд танилцуулна. Эцсийн найруулгыг танилцуулах ажлыг УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга хариуцна.

Санал хураалтыг ямар журмаар явуулдаг вэ?



САНАЛ ХУРААЛТ.



Үндсэн хууль, бусад хуульд нууц санал хураалт явуулж шийдвэрлэхээр зааснаас бусад тохиолдолд санал хураалтыг илээр явуулна. Ил санал хураалтыг гар өргөж, эсхүл цахим тоолуураар, харин нууц санал хураалтыг санал хураах хуудсаар, эсхүл цахим тоолуур ашиглан явуулдаг байна.

Улсын Их Хурлын гишүүн тухайн өдрийн нэгдсэн хуралдаанд ирцээ бүртгүүлсэн бол хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд санал хураахад заавал оролцоно. Хуульд заасан журмын дагуу санал хурааж нэгэнт баталсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санал хураах үед байгаагүй гэсэн шалтгаанаар Улсын Их Хурлын гишүүн дахин хэлэлцүүлэх эрх эдлэхгүй.

Санал хураах үед байгаагүй гэсэн шалтгаанаар Улсын Их Хурлын гишүүн уг асуудлыг дахин хэлэлцүүлэх эрх эдлэхгүй

Улсын Их Хурлын гишүүн зөвхөн “зөвшөөрсөн”, “татгалзсан” гэсэн 2 саналын⁴ аль нэгийг өгнө. Хуралдаанд оролцож байгаа боловч санал өгөхгүй байгаа гишүүнийг татгалзаж байгаад тооцно.

Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан дээр Улсын Их Хурлын гишүүн тухайн санал хураалгаж байгаа асуудлаар өөрийн нэрээр нэг л удаа санал өгөх ёстой байдаг.



2001

⁴ Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг. 2001 он. 25-ийн 4 дэх заалт.

3.4. ХУУЛИЙГ ЁСЧЛОХ, НИЙТЛЭХ, МЭДЭЭЛЭХ

УИХ-ын нэгдсэн хуралдаанаар эцсийн хэлэлцүүлэг хийгдэж, батлагдсан хуулийг хэрхэн ёсчлох, хэвлэн нийтлэх, мэдээлэх асуудлыг тусгайлан зохицуулсан байдаг.

Хуулийг ёсчлох, хуульд Ерөнхийлөгч хориг тавих

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлд Ерөнхийлөгчийн бүрэн эрхүүдийг тогтоож өгсөн байдаг. “Бүрэн эрх” гэж тусгайлан заасны учир бол тэрхүү эрхүүдийг Ерөнхийлөгч хэнтэй ч хуваалцахгүй эдлэх бөгөөд бас хэнд ч шилжүүлж болохгүй эрхүүд байдагт оршдог.

Латины “veto” буюу монголоор хориглох гэсэн утгаар илэрдэг хууль зүйн энэхүү ойлголт, зохицуулалт нь хууль тогтоох байгууллагаас гаргасан хууль болон бусад шийдвэрийн үйлчилгээг саатуулах буюу зогсоох талаар төрийн тэргүүний эдлэх бүрэн эрхийн тухай асуудал юм. Манай улсын хувьд Ерөнхийлөгчийн хориг тавих эрх нь харьцангуй хоригт тооцогддог. Учир нь төрийн тэргүүний тавьсан хоригийг хууль тогтоогч дахин хэлэлцэж, хүчин төгөлдөр болж үйлчлэх эсэхийг шийдвэрлэдэг онцлогтой.

Улсын Их Хурал хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн эцсийн найруулгатай танилцсанаас хойш ажлын 3 өдрийн дотор Улсын Их Хурлын дарга уг шийдвэрт гарын үсэг зурж ёсчилно.

Улсын Их Хурлын шийдвэрийг ёсчилсноос хойш 24 цагийн дотор Монгол Улсын Ерөнхийлөгчид илгээнэ.

Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих эрх нь Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн нэг бөгөөд Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж, чуулганд оролцсон нийт гишүүний гуравны хоёр нь хүлээж аваагүй бол уг хууль, шийдвэр хүчин төгөлдөр хэвээр үлдэхээр Үндсэн хуулийн 33 дугаар зүйлд заасан байдаг.

Ерөнхийлөгч УИХ-ын дарга гарын үсгээ зурж ёсчилсон хуулийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан хориг тавих эсэхээ шийдвэрлэдэг. Хэрэв энэ хугацаанд Ерөнхийлөгч хориг тавиагүй бол уг хууль хүчин төгөлдөр болох дараагийн шатандаа ордог.

Ерөнхийлөгч УИХ-аас гаргасан хуульд бүхэлд нь буюу аль нэг бүлэг, зүйл, хэсэгт хориг тавих эрхтэй. Ийнхүү хориг тавих үндэслэл нь уг хуулийн заалт Үндсэн хуулийг зөрчсөн, түүнчлэн бусад хууль, манай улсаас нэгдэн орсон олон улсын гэрээний заалттай зөрчилдөж байгаа, үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж мэдэх, ард түмний ёс заншилд үл тохирох, цаг хугацаа алдсан буюу эртэдсэн зэргээс эхлээд амьдралд нийцэхгүй, хууль тогтоох журам, техникийг

Хууль тогтоох байгууллагаас гаргасан хууль болон бусад шийдвэрийн үйлчилгээг түр саатуулах буюу зогсоох талаар төрийн тэргүүний эдлэх бүрэн эрх нь хориг тавих юм.

зөрчсөн гэх мэт хууль зүйн болон зан заншил, аж амьдралын олон зүйл байж болно.

Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди 1997 оноос өнөөдрийг хүртэлх хугацаанд УИХ-ын тогтоолд нийт 27 удаа хориг тавьсан байна. Үүнээс 19 хоригийг УИХ хүлээн авч, 8 хоригийг хүлээн аваагүй байна.

Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг УИХ-аар хэлэлцэх

Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг УИХ хүлээн авмагц хэлэлцэх асуудлын ээлж дараалал хүлээхгүйгээр нэн даруй хэлэлцэж, хүлээн авах эсэхийг шийдвэрлэнэ. Хориг хэлэлцэж байгаа чуулганы хуралдаанд оролцсон нийт гишүүний дийлэнхи олонхи буюу гуравны хоёр нь хүлээж аваагүй бол уг хууль хүчин төгөлдөр болох дараагийн шатандаа орно. Өөрөөр хэлбэл, Ерөнхийлөгчийн тавьсан хориг хүчингүй болох юм.

Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг хүлээн авах

Хэрвээ гишүүдийн гуравны хоёр нь хоригийг хүлээн авсан бол хориг тавьсан хууль, хамаарах бүлэг, зүйл, заалтыг хүчингүй болгох, эсхүл өөрчлөх ёстой. Зарим үед Ерөнхийлөгч хуулийн хэд хэдэн заалтад хориг тавих тохиолдол байж болох бөгөөд энэ үед УИХ уг хоригийн заримыг хүлээн авч, заримыг нь хүлээн авахаас татгалзсан байж болно.

Жишээ нь, Төрийн албаны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн 9.1.5 дахь заалтад 2003 оны 1 сарын 8-ны Е/4 тоотгоор тавьсан хоригийг УИХ хүлээн авсан. Шүүхийн тухай хуулийн 15.2 дахь заалтад 2002 оны 7 сарын 22-ны Е/37 тоотгоор тавьсан хоригийг УИХ хүлээн аваагүй байна.

Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авахгүй талаар УИХ-аас гаргасан шийдвэр эцсийнх байдаг. Гэсэн хэдий ч Ерөнхийлөгч хуулийг Үндсэн хууль зөрчсөн гэж хориг тавьсныг УИХ хүлээн аваагүй тохиолдолд Үндсэн хуулийн Цэцэд хандаж хянан шийдвэрлүүлэх эрхтэйн зэрэгцээ өргөсөн тангарагаа хэрэгжүүлэх үүднээс үүрэгтэй⁵ юм. Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг УИХ хүлээн аваагүй үед Үндсэн хуулийн Цэцэд хандсан тохиолдол П.Очирбат, Н.Багабанди нар Ерөнхийлөгч байх үед гараагүй байна.

Хууль хүчин төгөлдөр болох

Хууль хүчин төгөлдөр болох гэдэгт УИХ-аар батлагдсан хуулийг бүх нийтээр дагаж мөрдөх албан ёсны хүчин чадалтай болж эхлэх хугацааны тухай ойлголт юм. Тэгвэл батлагдсан хууль хэзээ хүчин төгөлдөр болох вэ гэдэг асуулт гарч ирнэ. Энд хоёр үндсэн зохицуулалт байдаг байна. Үүнд:

1. *Тухайн хуулийг батлахдаа хэзээнээс эхлэн хүчин төгөлдөр болох тухай асуудлыг урьдчилан тусгайлан заасан байх. Тухайлбал, Монгол Улсын Иргэний шинэ хууль 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлагдсан. Харин хүчин төгөлдөр*

⁵ Г.Совд “Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар” УБ., 2000 он. 169 дэх тал

болох хугацааг 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөхөөр хууль гарсан байна.

- 2. Улсын Их Хурлын тухайн шийдвэрт дээрхийн адил өөрөөр заагаагүй бол уг хууль албан ёсоор нийтлэгдсэнээс хойш 10 хоногийн дараа хүчин төгөлдөр болдог.*

Хуулийг албан ёсоор нийтлэх

Батлагдан гарсан хуулийг заавал нийтлэх шаардлага тавигддаг. Та энэ тухай эрх зүйн хэм хэмжээ заавал бичигдмэл байх ёстой талаар бичсэн эхний бүлгээс уншсан билээ. Хуулийг ямар хэвлэлд нийтлэх, энэ асуудлыг хэн хариуцах вэ гэдэг асуудлыг нарийвчлан зохицуулсан байдаг. УИХ-ын Тамгын газар нь УИХ-аас баталсан хууль, бусад шийдвэрийн эцсийн найруулга хийх, хэлбэржүүлэн гаргах, нийтлэх, мэдээлэх үүргийг хуулиар хүлээдэг. Хуулийг УИХ-ын Тамгын газраас эрхлэн гаргадаг "Төрийн мэдээлэл" эмхтгэлд албан ёсоор нийтэлдэг бөгөөд үүнийг албан ёсны эх гэж үздэг. "Төрийн мэдээлэл" эмхтгэлд хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, хуулийн талаархи Улсын дээд шүүхийн албан ёсны тайлбар, яам, агентлагаас гаргасан нийтээр дагаж мөрдөх эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актыг бүрэн эхээр нь нийтэлнэ.

Улсын Их Хурлын чуулганы явцын тухай олон нийтэд сонордуулах

Улсын Их Хурлын чуулганы явцын тухай олон нийтэд сонордуулах тэмдэглэлийг Улсын Их Хурлын номын санд тавьдаг. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны явцын тэмдэглэлийг гараар болон соронзон хальсанд нэгэн зэрэг бичнэ. Шаардлагатай гэж үзвэл албан ёсны мэдээллийг зөвхөн УИХ-ын Тамгын газар хариуцан нийтлүүлэх үүрэгтэй. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны хуралдааны явцын талаар дуутай дүрс бичлэг хийж хадгалдаг байна.

Эдгээрийг Улсын Их Хурлын чуулганы материал бэлтгэж хэвлүүлэх, хэвлэл, мэдээллийн байгууллагад лавлагаа өгөх, маргаантай асуудал шийдвэрлэхэд ашиглуулж болдог ажээ.

Ингээд бид хууль батлагдан гарч, хүчин төгөлдөр болж үйлчлэх тухай тодорхой мэдлэгтэй боллоо. Иймээс иргэн бид өөрсдийн бүхий л үйл ажиллагаандаа хуулиа дээдлэн, түүнийг дагаж мөрдөх хэрэгтэй гэдэг нь ойлгомжтой.

Түүнчлэн хуулийн үйлчлэлийн талаар, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах, шинээр хууль батлах шаардлага, хэрэгцээ зэргийгээ хууль санаачлагчид уламжлах эрхээ хэрхэн эдлэх, хуулийн төслийг ард нийтээр хэлэлцүүлэх явцад та хэр зэрэг идэвх санаачилгатай оролцохоос их зүйл шалтгаалдаг юм гэдэгтэй хүн бүхэн санал нэгтэй байх биз ээ.

Á - ÈÝÃ 4. Õóóëü áçòýýõ çéë àæèëëääààí ääõü èðãýí èé îðîëîîî

4.1 Иргэний оролцооны тухай

4.2 Лобби ба Хууль

Энэ бүлгээс бид хууль бүтээх болон шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь иргэний оролцоо, оролцох арга замууд, лобби хийх тухай, түүнд ямар зүйлийг анхаарах талаар мэдэж авах болно.

4.1 ИРГЭНИЙ ОРЛОЦООНЫ ТУХАЙ

Ардчилсан нийгмийн гол үнэт зүйл нь засаглал дахь ард иргэдийн оролцоо байх учиртай. Энэ нь хууль батлан гаргахад иргэд оролцохоос илүү өргөн хүрээтэй ойлголт юм.

Төр засаг нь бодлого боловсруулах, хууль тогтоох, шийдвэр гаргах зэрэг үйл ажиллагаанд иргэдийг оролцох боломжоор хангах үүднээс тэдэнд холбогдох мэдээллийг хүргэх, уулзалт, зөвлөгөөн зохион байгуулах, санал хураалт явуулах зэрэг олон ажлуудыг зохион байгуулдаг байна. Нөгөө талаас иргэд хуулиар олгогдсон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, сонгох, сонгогдох эрхээ ухамсарлан иргэнийхээ хувьд төрийн үйл хэрэгт хувь нэмрээ оруулах шаардлагатай.

Сүүлийн үед хийгдсэн зарим судалгаанаас үзэхэд манай иргэд сонгуульд дөрвөн жилийн хугацаанд нэг удаа саналаа өгөх төдийхнөөр төрийнхөө үйл хэрэгт оролцож байгаа нь тогтоогдсон.

Гэтэл бодлого тодорхойлох, төрийн үйл ажиллагаанд иргэд санал бодлоо оруулах олон арга хэлбэрүүд байсаар байна. Бид өмнөх бүлгүүдэд хууль гаргах үйл ажиллагаанд иргэн хүн хэрхэн оролцож болох талаар өгүүлсэн билээ. Харин энэ хэсэгт оролцооны бусад хэлбэрүүдийн талаар авч үзэх болно.

Манай улсад ардчиллын оролцооны үндсэн хоёр хэлбэр байна. Шууд бус ардчилал гэдэгт иргэд бид сонгогдсон УИХ-ын гишүүн болон өөрийн оршин суугаа аймаг, нийлэл, сум, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчдөөр дамжуулан шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцохыг хэлж байна. Шууд ардчилал гэдэг нь та бид аливаа төр, нийгэм, орон нутгийн хүрээний асуудлыг шийдэх үйл хэрэгт өөрийн биеэр оролцохыг ойлгож болно. Жишээ нь өөрийн оршин сууж буй баг, хорооныхоо Иргэдийн нийтийн хуралд оролцох.


Иргэдийн хувьд шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, нөлөөлөх дараах арга замуудыг ашиглаж болно.

- УИХ-ын гишүүнээр дамжуулах;
- Ард нийтийн санал асуулга явуулахад оролцох;
- УИХ-ын чуулганаар хэлэлцэх хууль, бусад шийдвэрийн төслийг олон нийтээр хэлэлцэхэд оролцох;
- Оршин суугаа Засаг захиргааны нэгжийн ИТХ¹ ба ИНХ²-д оролцох;
- Төрийн бус байгууллагаар дамжуулах;

**Өөрийн аж
амьдрал
болон
нийгэмтэй
холбоотой
аливаа улс
төрийн
шийдвэр
гаргахад бүх
иргэд оролцох
эрхтэй.**

¹ Иргэдийн төлөөлөгчдийн хурал

² Иргэдийн нийтийн хурал



УИХ-ын гишүүнээр дамжуулах

Иргэд өөрт тулгамдсан болон шийдвэрлүүлэх шаардлагатай асуудлаа өөрийн тойргоос сонгодсон УИХ-ын гишүүнтэй биечлэн уулзах мөн түүний бие төлөөлөгч, туслах зэрэг хүмүүсээр дамжуулан тавьж болно. Манай иргэд УИХ-ын гишүүдтэй уулзах уулзалтаар ихэвчлэн шууд хөрөнгө мөнгөтэй холбоотой асуудлуудыг тавьж шийдвэрлүүлэхийг илүүтэй шаарддаг. Гэтэл хуулийн дагуу УИХ-ын гишүүн гэдэг нь төсөв, мөнгийг захиран зарцуулагч бус хууль санаачлан, хууль батлах, бодлого тодорхойлох чиг үүрэг бүхий улс төрийн албан тушаалтан байдаг.

Нэг талаас УИХ-ын гишүүн нь ард нийтийн санаа, бодлыг төлөөлж төрийн үйл хэрэгт шууд оролцох зорилгоор иргэдийн сонголтыг өөртөө авч байгаа юм.

Харин үүний хариуд УИХ-ын гишүүн нь сонгогчидтойгоо ойр дотно харилцаж тодорхойлох гэж буй бодлого, батлан гаргах хууль зэргийн талаар тэдэнтэй санаа бодолоо хуваалцаж, хамтран ажиллах үүргийг хүлээж байдаг.

Ард нийтийн санал асуулга явуулахад оролцох

Улсын их Хурал ард нийтийн санал асуулга явуулах талаар ил санал хураалт явуулж, УИХ-ын тогтоол батална. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар сонгуулийн эрх бүхий иргэдийн олонхи нь оролцсон ард нийтийн санал асуулгыг хүчинтэйд тооцож, олонхийн санал авсан асуудлыг шийдвэрлэгдсэн гэж үзнэ. “Ард нийтийн санал асуулгын тухай хууль”-ийг 1995 онд батлан гаргасан байна.

Санал асуулгад Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд оролцож, санал асуулгаар шийдвэрлэх асуудлын талаар саналаа нууцаар гаргана. Санал авах өдөр эх орондоо байгаа 18 насанд хүрсэн Монгол Улсын иргэн үндэс угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол,

Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана. Монгол улсын Үндсэн хуулийн 4-р бүлэг, 57-р зүйлийн 1.

боловсрол ялгаварлахгүйгээр санал асуулгад оролцож саналаа өгөх эрхтэй. Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр ухаан солиотой нь нотлогдсон, түүнчлэн хорих газар ял эдэлж байгаа хүн санал асуулгад оролцохгүй. Санал асуулгаар шийдвэрлэх асуудал:

1. Санал асуулгыг төрийн дотоод, гадаад бодлогыг тодорхойлохтой холбогдсон тодорхой асуудлаар ард нийтийн сонголт хийлгэх шаардлага гарсан тохиолдолд явуулна.

2. Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар ард нийтийн санал асуулга явуулж болно.

3. Нэг удаагийн санал асуулгыг хоёроос дээшгүй асуудлаар явуулна.

УИХ-ын чуулганаар хэлэлцэх хууль, бусад шийдвэрийн төслийг олон нийтээр хэлэлцэхэд оролцох

УИХ-ын чуулганаар хэлэлцэх гол гол хууль, бусад шийдвэрийн төсөлд иргэд, байгууллагаас санал авах зорилгоор УИХ-ын холбогдох Байнгын хорооноос нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулдаг. Өдөр тутмын хэвлэлд хууль, бусад шийдвэрийн төслийг хэвлэн нийтэлнэ. Иргэд хуулийн төслийн талаарх саналаа УИХ-ын иргэдийг хүлээн авах байранд биеэр ирж амаар болон бичгээр өгөхөөс гадна сонины газарт эсхүл Байнгын хороонд хаяглан шуудан, цахилгаан шуудан /имэйл/, факсаар илгээж болно.

Хэлэлцүүлгийн хугацаанд ирсэн санал, хүсэлтийг нэгтгэн Байнгын хороонд албан ёсоор танилцуулдаг ба түүний тоймыг хэвлэлд нийтэлдэг. Иргэд, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлтийг төсөлд хэрхэн тусгасан талаар хэвлэлээр дамжуулан мэдээлдэг. Хуулийн төсөл боловсруулах ажил болон хуулийн төслийн хэлэлцүүлэгт иргэн хэрхэн оролцох боломжтой талаар бид энэ номын хоёр, гуравдугаар бүлэгт тодорхой үзсэн билээ.

Засаг захиргааны нэгжийн ИТХ ба ИНХ-д оролцох

Манай улсын иргэн бүр нь хуулийн дагуу тодорхой засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид оршин сууж, түүнд харъяалагддаг.

Засаг захиргааны нэгжийн удирдлага нь нэг талаас Засаг даргаар дамжсан төрийн удирдлага нөгөө талаас орон нутгийн ИТХ, ИНХ-аар зохион байгуулагдсан нутгийн өөрөө удирдах ёсыг хослуулах зарчим дээр хэрэгждэг. Манай улсын 21 аймаг, нийслэл, 329 сум, 9 дүүрэг бүрт ИТХ ажиллаж тэнд 7475 төлөөлөгч иргэн сонгогдон ажиллаж байна. Мөн 1579 баг, 121 хороонд иргэдийн Нийтийн хурал ажиллаж манай улсын иргэн бүрт өөрийн оршин суугаа харъяаллаар энэ хуралд шууд оролцох боломж хуулиар олгогдсон.

Ардчилсан засаглал нь хууль ёсны бөгөөд мэдрэмжтэй, төлөөлөл болон оролцоог хангасан, ил тод бөгөөд хариуцлагатай, хууль дээдлэх ёсонд үндэслэсэн тогтолцоо юм.



ИТХ ба ИНХ-аар юу хэлэлцдэг вэ?

Аливаа хурал нь дээд шатныхаа хурал, бусад байгууллагын эрх хэмжээнд хамаарахаас бусад нутаг дэвсгэрийн амьдралын ямарч асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж болдог. Эдгээрээс нутаг дэвсгэрийн нэгжийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн төлөвлөгөө, төсөв, санхүүгийн үйл ажиллагаа, нийтийн ариун цэвэр, хог, хаягдал зайлуулах, гал түймэртэй тэмцэх, усан хангамж, орон нутгийн зам засвар, дэд бүтцийн асуудлыг хариуцан шийдвэрлэдэг.

Мөн тухайн шатны Засаг даргыг томилуулахаар нэр дэвшүүлэх, чөлөөлүүлэх, огцруулахаар дээд шатны Засаг дарга, Ерөнхий сайдад санал болгох, Засаг даргын ажлын тайланг хэлэлцэж үйл ажиллагаанд нь дүгнэлт өгөх, хуулийн төсөл, төр нийгмийн амьдралын чухал асуудлыг ард нийтээр хэлэлцүүлэх, санал асуулга явуулах асуудлыг нутаг дэвсгэртээ зохион байгуулах эрхтэй байдаг.

ИТХ ба ИНХ нь ямар хугацаанд хуралддаг вэ? Түүнд хэрхэн оролцох вэ?

ИТХ-ын үндсэн үйл ажиллагаа нь хуралдаан байдаг ба хуралдааны чөлөөт цагт хурлын тэргүүлэгчид үйл ажиллагаагаа явуулж байдаг. Аймгийн ИТХ нь тухайн засаг захиргааны нэгжийн хүн амын тооноос хамаарч 25-35, сумынх 15-25, нийслэлийн ИТХ 40, томоохон дүүргүүд 35 төлөөлөгчидтэй байдаг. Хурлын тэргүүлэгчээр эдгээр төлөөлөгчдөөс 5-9 хүн сонгогдон ажилладаг. Баг, хорооны хурал нь 3-5 тэргүүлэгчидтэй байдаг.

Хуралдаан нь ээлжит ба ээлжит бус гэсэн хоёр хэлбэртэй байдаг. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ээлжит хуралдааныг жилд нэг удаа, баг, хороонд жилд хоёроос доошгүй удаа хийхээр хуульчлан заасан. Ээлжит бус хуралдаан нь Засаг даргын санаачлага, Хурлын тэргүүлэгчдийн шийдвэрээр хуралдаж болдог. Иргэд энэхүү

Бүх талын оролцоо бүхий нийгэм, үндэсний хэмжээнд шийдвэр гаргах үйл явцад иргэдээ оролцох боломжоор хангаж өгөх ёстой.

хуралдааныг хуралдуулах талаар дээрх субъектүүдэд санал тавьж болно.

Оршин суугаа баг, хорооны ИНХ-ын хуралдаанд сонгуулын насны иргэн бүр шууд оролцох ба хуралдааныг багт 5 өрх, 50-иас дээш мянган хүн амтай сумын багт 10, хороонд 15 өрх тутмаас сонгуулийн насны тус бүр нэг хүн хүрэлцэн ирсэн тохиолдолд хуралдааныг хүчинтэйд тооцдог.


Иргэд Хурлын төлөөлөгчид, тэргүүлэгчид болон олон нийтийн байгууллагаар дамжуулан Хурлын хуралдаанд асуудал хэлэлцүүлэхээр оруулж болно. Хурлын хуралдааны товийг өөрийн баг, хорооны төв дээр очиж мэдэж болох ба ихэвчлэн хорооны ажилтнууд айлуудаар явж хурлын товийг зарладаг.

Засаг дарга ба иргэд

Монгол улсын аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороон бүр нь Засаг даргатай байх ба тэрээр төрийн хэргийг төлөөлөн орон нутагт ажилладаг улс төрийн албан тушаалтан юм. Аймаг, нийслэлийн Засаг даргыг аймаг, нийслэлийн ИТХ-аас нэр дэвшүүлж Ерөнхий сайд томилдог бол сум, дүүрэг, баг хорооны Засаг даргыг тухайн шатны Хурлаас нэр дэвшүүлж засаг захиргааны дээд нэгжийн Засаг дарга томилдог.

Засаг дарга нь төрийн дээд байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэхийн хамт тухайн нэгжийн Хурлын шийдвэрийг биелүүлдэг. Иргэд өөрийн амьдран суугаа баг, хорооныхоо Засаг даргад өөрийн төлөө ажиллаж чадах хүнийг нэр дэвшүүлэх эрхтэй ба бусад түвшингийн хувьд сонгосон ИТХ-ын төлөөлөгчөөр дамжуулан энэ тухай санал бодолоо илэрхийлж болно.

Аливаа байгууллага, аж ахуйн нэгжийн гаргасан шийдвэр тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн хууль ёсны ашиг сонирхолд харшилж байвал иргэд энэ асуудлаа Засаг даргад тавьж түүнийг хүчингүй болгуулж болдог.




Монгол улсын аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороон бүр нь Засаг даргатай байх ба тэрээр төрийн хэргийг төлөөлөн орон нутагт ажилладаг улс төрийн албан тушаалтан юм.

Иргэдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, иргэний бүртгэлийн үйлчилгээ зэрэг нь Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд хамаарагддаг. Иргэд дээрх үйлчилгээтэй холбоотой асуудлуудаа Засаг даргад шууд тавих, сонгосон төлөөлөгчөөрөө дамжуулан оруулах боломжтой. Ялангуяа засаг захиргааны нэгжийн хамгийн доод нэгжийн буюу баг, хорооныхоо Засаг даргатай байнга харилцаж, хорооныхоо хуралд идэвхитэй оролцож байх нь оролцоо бүхий нийгмийг төлөвшүүлэхэд нэн чухал үүрэгтэй.

Төрийн бус байгууллагаар дамжуулах

Ардчилсан нийгэмд иргэдийн оролцоог хангадаг гол хэрэгсэл нь иргэд сайн дурын үндсэн дээр ашиг сонирхолынхоо дагуу эвсэл, холбоо, төрийн бус байгууллагад эвлэлдэн нэгдэж шийдвэр гаргах үйл ажиллагаанд өөрийн санал бодлыг тусгуулах, нөлөөлөх явдал байдаг.

Төрийн бус байгууллагыг үүсгэн байгуулах асуудлыг төр засгаас хуульчлан зохицуулсан. Өнөөдөр Монгол улсын хэмжээнд 2700 гаруй төрийн бус байгууллагууд үйл ажиллагаагаа явуулж байна. Гэвч эдгээрийн ихэнх нь хөдөө орон нутагт бус Улаанбаатар хотод төвлөрч байна.



Т.Б.Б-д эвлэлдэн нэгдэн болдог.

Төрийн байгууллагаас тэр болгон үр дүнтэй байдлаар хүрч ажиллаж чадахгүй нийгмийн эмзэг хэсгийнхний ашиг сонирхолыг төлөөлөн илэрхийлэхэд төрийн бус байгууллагууд нь чухал үүрэг гүйцэтгэх учиртай.

Иргэдийн зүгээс төрд санаа бодолоо хүргэхдээ тухайн чиглэлээр дагнаж туршлага хуримтлуулсан, ашгийн бус нийгмийн болоод гишүүдийнхээ эрх ашгийн төлөө ажилладаг төрийн бус байгууллага, эвсэл, холбоонд нэгдэн орох нь иргэний нийгэмд байдаг оролцооны гол арга зам юм.

4.2 Лобби ба Хууль

**Ардчилсан
нийгэм бол
бүх талын
оролцоог
хангасан
нийгэм мөн.**

Лобби гэдэг үг Монгол хэлний үгсийн санд орж ирээд удаагүй байгаа тул шууд тохирсон, утга санааг нь бүрэн илэрхийлсэн үг хэллэг харахан алга байна. "Лобби" гэдэг нь уг гарлын хувьд "Үүдний өрөө, коридор" гэсэн утга санаатай боловч хүрээ нь түүнээс хамаагүй илүү өргөн дэлгэр.

Энэ үг нь анх парламентийн гишүүд, өөрсдийн нөхөдтэйгөө аливаа нэг хэлэлцүүлгийн өмнө буюу дараа уулзаж зөвшилцдөг "лобби" буюу "задгай танхим"-аас үүсэл гаралтай. Тухайн үед аливаа нэг асуудал, хууль тогтоомжийн талаар үзэл бодлоо илэрхийлэх, хууль тогтоогчидтой уулзах хүсэлтэй хүмүүс тэр лобби хавиар байнга эргэлдэж, цугларч байдаг байжээ.



Зарим хувь хүмүүс, байгууллагууд шийдвэр гаргагчдыг дэндүү, хол зайтай, тэдэнд хүрч болшгүй гэж боддог, мөн заримынх нь хувьд лобби гэдэг нь нэг л ойлгомжгүй, буруу зүйл мэт сонсогдох тул лобби хийхийг боломжгүй гэж үздэг.

Лобби хийх нь шийдвэр гаргагчдад өөрийн итгэл үнэмшил дээрээ тулгуурлан тодорхой асуудал, тодорхой бодлого, хуулийн талаар үзэл бодлоо илэрхийлэх, улмаар өөрийн хүсч буй үр дүнгээ гаргуулахын тулд нөлөөлөх явдал мөн.

Харин лоббидох боломжит арга замуудад хууль, бодлого тогтоогчидтой холбоо барих, тэдэнд өөрийн үзэл бодол, санаагаа ойлгомжтойгоор илэрхийлэх, тухайн асуудлаар өөр саналтай буй хүмүүсийн үндэслэлийг няцаах, өөрт буй баталгаа дэмжлэгийг харуулах зэрэг орно. Барууны улс орнуудын парламентад гарч буй олон шийдвэрүүд нь хууль тогтоогчдыг сонгосон ард иргэд, тухайн орон нутгийн бизнес эрхлэгчид, янз бүрийн бүлэглэлүүдийн хийсэн лоббины үр дүн байдаг ажээ.

Лоббиг хэн хийж болох вэ?

Хэн ч хийж болно. Та заавал аль нэг байгууллагын төлөөлөл байх албагүй. Энгийн нэг иргэн хүн ч тодорхой хууль, эрх зүй, бодлогын асуудлаар өөрийн үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл өгөх зорилгоор шийдвэр гаргагчидтай утсаар ярих, захиа бичих, уулзах боломжтой. Харин гадаадын орнуудад зарим нэг төрийн бус байгууллагуудыг лобби хийхийг хориглосон байдаг ажээ.

Лоббиг яаж хийх вэ?

Бодлогын нэг тодорхой асуудал дээр төвлөрч, лоббигоо зөвхөн тухайн асуудалд л чиглүүлэх хэрэгтэй. Уг асуудлаа сайтар судалж, холбогдох мэдээллийг цуглуулах нь чухал. Тухайн асуудлаар зөвхөн маш хүчтэй үзэл бодол, итгэл үнэмшилтэй байх нь хангалттай биш. Өөрийн үзэл бодлоо нотлон харуулахын тулд янз бүрийн эх сурвалжуудаас (хэвлэл, ном, судлагаа, статистик, баримт жишээ гэх мэт) бодит, зөв, шинэлэг мэдээ, материал олж бүрдүүлсэн байдаг. Хамгийн гол нь мэдээлэл нь маш зөв, алдаа мадаггүй байх ёстой.

Өөрийн хүсч буй өөрчлөлт, үйл ажиллагааг маш сайн тодорхойл. Шийдвэр гаргагчдаар дэмжүүлэх хүсэлтэй байгаа саналаа нарийн бэлтгэнэ. Хэлэлцэх, буулт хийх явдал гарч болзошгүй тул тухайн асуудал дээр өөр нэг хувилбар бэлтгэсэн байвал сайн байдаг. Шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн хүмүүсээс жишээ нь хуульч, эмч гэх мэт мэргэжилтнүүдээс туслалцаа авахыг хичээ.

Асуудлаа шийдвэр гаргачид товчхон, зөв дарааллаар нь танилцуулж, логиктой ярих шаардлагатай. Гэхдээ хууль тогтоогч, шийдвэр гаргагчид тухайн асуудлаар нарийн мэдлэггүй байж болохыг санаарай. Аль болох үнэнийг ярьж, асуудлыг хэтрүүлэн, дэврүүлж болохгүй.

Лобби хийх гэж буй бол тухайн асуудлаар шийдвэр гаргах зарчим, үе шатуудыг урьдчилан ойлгож авсан байх хэрэгтэй. Үүнийг мэдэж авснаар тухайн асуудлын талаар хийгдэж буй ажлын явцыг хянах, харах боломжтой болно.

Шийдвэр гаргагч гол хүмүүсийг мэдэж аваад чухам хэнд нь хандахаа шийд. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллага, хувь хүмүүсээс асуух замаар хэн нь таны саналыг дэмжих буюу эсэргүүцэх талаар урьдчилсан тандалт хийх нь зүйтэй. Ганц нэг хүн дээр бүх найдлагаа тавьж болохгүй. Түүнчлэн таны санааг эсэргүүцэгчид мөн дэмжих шийдвэр гаргагчид хэн байхыг таамаглах нь зүйтэй.

Таны тавьж буй асуудлаар шийдвэр гаргагч бүрийн барьж буй байр суурийг сайтар судалж, нөлөөлөх гэж оролдож буй асуудлынхаа

Лобби хийх гэж буй бол тухайн асуудлаар шийдвэр гаргах зарчим, үе шатуудыг урьдчилан ойлгож авсан байх хэрэгтэй.

талаар байнга өөрийгөө шинэлэг мэдээллээр хангах, хэлэлцэгдэх төсөл, саналуудыг байнга ажиглаж байх нь чухал.

Лобби хийх цаг хугацаагаа зөв сонго. Шийдвэр гаргах үе шат нь ерөнхийд . Шийдвэр гаргах үе шат нь ерөнхийд жил тойрон үргэлжилдэг. Үүний зэрэгцээ албан бус шийдвэр гаргах үйл явцыг ажигла. Албан ёсны ихэнх шийдвэрүүд нь төрөл бүрийн цуглаан болон бусад албан бус уулзалтууд дээр дээр гардаг.. Тийм учраас та хэдийд ийм уулзалт, ярилцлага хийгдэх, ямар асуудал хэлэлцэхийг мэдэж байх ёстой. Ийм уулзалт, цуглаан дээр өөрийнхөө санааг илэрхийлэх боломжийг ашиглах нь зүйтэй юм.

Та хандахаар завдаж буй шийдвэр гаргачдынхаа талаар аль болох их мэдээлэл цуглуул. Тухайн шийдвэр гаргагчийн хамтран ажиллагчид, багтдаг бүлэглэл, сул болон давуу талуудыг нь мэдэж авахад илүүдэхгүй. Санал авсан байдал, урьд нь хашиж байсан албыг нь олж мэдэх хэрэгтэй.

Хууль тогтоогчтой харилцах арга замууд

Лобби хийх хамгийн чухал үе шат бол тухайн хууль тогтоочтой хэрхэн харилцаа үүсгэхээ тодорхойлох явдал билээ. Үндсэн гурван арга зам байдаг. Эдгээр нь, биечлэн уулзах, утсаар ярих, захидал бичих. Гурван арга гурвуулаа үр дүнтэй байж болно. Таны сонгох арга нь танд байгаа цаг хугацаа, нөөц боломжоос хамаарна.

Нүүр тулан уулзах

Биечлэн уулзах нь лобби хийх хамгийн сайн арга. Гэхдээ шийдвэр гаргагчтай уулзах, тэдэндтэй холбоо тогтоох нь амаргүй байж болно. Боломжтой бол урьдчлан цаг тохирч авах хэрэгтэй. Гэхдээ та түүнтэй албан болон албан бус уулзалтын үеэр мөн уулзаж болно. Энэ тохиолдолд та өөрийгөө танилцуулж аваад, түүнээс хэдхэн минут ярилцах боломж бий эсэхийг асуух хэрэгтэй. Биечлэн уулзах үедээ дараах зөвлөмжийг санаарай.



Лобби хийх цаг хугацаагаа зөв сонго.

УУЛЗАЛТЫГ ҮР ДҮНТЭЙ БОЛГОХ АРГА ЗАМУУД

- § Уулзалтанд цагтаа ир.
- § Өөрийгөө болон өөрийн төлөөлж буй байгууллагаа сайтар танилцуулж, ирсэн зорилгоо ойлгуул. Мөн өөрийн сонирхож буй асуудлаа тайлбарлаад өөрийн байр суурийг илэрхийл. Сайн бэлтгэлтэй очих, эелдэг байх.
- § Цаг гаргасанд нь талархлаа илэрхийлэх. Аль болох нөхөрсөг байх, сүрдүүлэхгүй байх.
- § Та өөр хэн нэгтэй уулзах болсон бол бүү гутар. Шийдвэр гаргагчид ерөнхийдөө их завгүй байдаг тул ажилтнууд нь мэдээлэл хүлээж аваад даргадаа дамжуулдаг. Ажилтантай нь сайн харилцаа үүсгэх нь тухайн шийдвэр гаргагчид хүрэх нэг сайн арга замын эхлэл билээ.
- § Санаагаа тодорхой илэрхийл. Хэрэв та өөрийн нөхөдтэйгээ очих бол хэн нэгнээр нь яриул. Өөрийн санааг аль болох цөөн үгээр илэрхийл.
- § Шийдвэр гаргагчид ямар үйл ажиллагаа, яагаад шаардлагатай байгааг хэл.
- § Тухайн шийдвэрийн үр нөлөө болон шийдвэр гаргагч нь яагаад таныг дэмжих ёстойг сайтар илэрхийл.
- § Өөрийн тань үзэл бодлыг дэмжих, батлах баримтыг ашигла.
- § Асуулт, мэтгэлцээнд бэлэн бай. Хэрэв аль нэг асуултын хариулт танд байхгүй бол түүнийгээ хэл. Судлаад хариу өгье гэж хэлж болно.
- § Хэлэлцээ хийх, буулт хийхэд бэлэн бай.
- § Татгалзсан хариу авах бэлтгэлтэй бай. Хэрэв таны хүсэлтийг татгалзвал асуудлыг хэд хэдэн хэсэгт хуваагаад шийдвэр гаргаж болох эсэхийг судал.
- § Сайн сонсогч бай. Тухайн шийдвэр гаргагч юм уу ажилтанд санаа бодлоо илэрхийлэх боломж олго.
- § Таны талд байгаа шийдвэр гаргагчид жич анхаарал тавь. Түүнээс бусад шийдвэр гаргагчидтай уулзах, холбоо тогтоох талаар зөвлөгөө хүс.
- § Шийдвэр гаргагчдаас ямар нэгэн үйлдэл хийхийг хүсэх хэрэгтэй. Хэзээ, юу хийхийг нь асуу.
- § Хэрэв тухайн шийдвэр гаргагч юмуу ажилтан нь таны үзэл бодлыг эсэргүүцвэл эелдэг л байх хэрэгтэй. Учир нь та ирээдүйд тэдэнтэй дахин уулзаж болзошгүй билээ.

Татгалзсан хариу авах бэлтгэлтэй бай. Хэрэв таны хүсэлтийг татгалзвал асуудлыг хэд хэдэн хэсэгт хуваагаад шийдвэр гаргаж болох эсэхийг хар.

Утсаар ярих

Хэрэв та цаг багатай, хол амьдардаг бол өөрийн сонгосон төлөөлөгч болон шийдвэр гаргагчтай утсаар ярьж болно. Дээр дурьдсан олон зөвлөгөө энд ч гэсэн хамааралтай. Гэхдээ шийдвэр гаргагчтай утсаар ярих үедээ санаагаа маш товчхон, оновчтой илэрхийлж түүнтэй эелдэг харилцах нь чухал. Урьдчилан сайн бэлтгэлтэй байх ёстой.




УТСААР ЯРИХ.

Шийдвэр гаргагчид тантай ярих цаг зав тун бага байгааг бодолцох нь зөв. Учир нь тэр бусад асуудлаар нэг өдөрт маш олон хүнтэй утсаар ярих шаардлагатай байдаг. Аль болох эерэг сэтгэгдэл төрүүлэхээр асуудлаа тайлбарлах хэрэгтэй.

Захидал бичих

Танд лобби хийхэд маш бага цаг зав, нөөц боломжтой бол шийдвэр гаргагч, бодлого тодорхойлогчдод захидал бичих нь хамгийн үр дүнтэй арга байж болох юм. Та өөрийн санаа бодолоо ухаалаг зөв илэрхийлэн түүнийг уншигчийн сонирхолыг татахуйц, мартагдахгүй байхаар бичихийг хичээ. Маш ойлгомжтой, тодорхой бай. Та өөрийн санаа зовж буй асуудлаа илэрхийлээд, яагаад дэмжиж эсхүл эсэргүүцэж байгаа, уг асуудлыг шийдвэрлэхэд ямар үйл ажиллагаа шаардлагатай байгаа зэргийг дурьд. Тухайн асуудалд хамаагүй, хэрэгцээгүй баримт, мэдээллийг бүү оруул.



ЗАХИДАЛ БИЧИХ.

Захидлынхаа эхлэл хэсгийг найрсаг өнгө аястай эхэлж, өөрийгөө танилцуулан, асуудлаа хүндэтгэсэн хэлбэртэйгээр бичих нь зохимжтой. Захидлын эцэст шийдвэр гаргагчид анхаарал тавьсанд талархалаа илэрхийлэн, буцах хаяг, холбоо барих утсаа тэмдэглэн үлдээх нь чухал. Одоо үед имэйл, факс нь мөн захидалын хариуг авах үр ашигтай хэрэгсэл гэдгийг анхаарах нь зүйтэй.

Байнга санаж байх зүйлс

Уулзалт болон, утсаар ярьсныхаа дараа талархалаа илэрхийлсэн захидал бичиж болно. Түүндээ өөрийн асуудлаа товчхон дурдаад, түүний амласан зүйлүүдийг дурьд. Шийдвэр гаргагч болон бодлого тодорхойлогч нь амласан зүйлүүдээ хийж буй эсэхийг нь сайн ажиглаж байх нь зүйтэй.

Өөрийн лобби хийсэн ажлаа үнэлж, амжилт, алдаа, урам хугаралт, сурсан зүйлээ эргэн харж, өөрийн бүлгийнхэн болон бусадтай олж мэдсэн туршлагаа хуваалцах хэрэгтэй.

Шийдвэр гаргагчид, сонгогдсон гишүүд өөрсдийг нь сонгосон хүмүүст анхаарлаа хандуулдаг гэдгийг санаж бай. Та ч бас тэдэнд хэрэгтэй!

Аль болох бусад хүмүүстэй ярилцаж, саналыг нь асууж асуудлаа хамтран тавих нь үр дүнтэй байдаг. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлийг ашиглан, тэдэнтэй байнга холбоотой байж өөрийн асуудалаа дэлгэрүүлэн бичиж, хэвлүүлж байх нь лобби хийхэд түлхэц болно.

Амжилттай лоббидох нэг үндэс бол бага багаар урагшлах явдал. Өчүүхэн жижиг ялалт ч гэсэн таны урагшаа явах тулгуур болно. Та хэдийгээр өөрийн зорьсон үр дүндээ хүрэхгүй байлаа ч гэсэн лобби нь танд өөрийн итгэл үнэмшлийг ажил хэрэг болгох, шийдвэр гаргах процесст оролцох боломж олгодог билээ. Эцэст нь танд зориг, тэвчээр, итгэл үнэмшил, өөрчлөх гэсэн сэтгэлийн хүч хамгаас илүү хэрэгтэй.

Өөрийн лобби хийсэн ажлаа үнэлж, амжилт, алдаа, урам хугаралт, сурсан зүйлээ эргэн харж, өөрийн бүлгийнхэн болон бусадтай олж мэдсэн туршлагаа хуваалцах хэрэгтэй.

Ашигласан материалын жагсаалт

Нэг. Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он.
 2. Монгол Улсын Их Хурлын тухай хууль. 2001 он.
 3. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль. 1993 он
 4. Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хууль 1997 он.
 5. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль 1993 он.
 6. Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хууль. 2001 он.
 7. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг 2001 он.
 8. Монгол Улсын олон улсын гэрээний тухай хууль 1993 он.
- “FIND LAW” хуулийн мэдээллийн программаас хууль тогтоомжийг ашиглав.

Хоёр. Бусад

1. Г.Совд. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. 2000 он.
2. Эрх зүйн мэдлэгийн товч толь. Редактор Ж.Амарсанаа. /хамтын/ 1986 он.
3. С.Нарангэрэл, Н.Лүндэндорж. Эрх зүй судлалын удиртгал. 2002 он.
4. Д.Солонго. Төрийн эрх зүйн тайлбар толь. 2003 он.
5. Д.Лүндээжанцан, Ч.Энхбаатар. Үндсэн хуулийн эрх зүй. 2001 он.
6. “Монголын төр, эрх зүй” сэтгүүл. 2003 он. дугаар 3.
7. The World Book Encyclopedia. Volume 12. 1995.
8. Business law and the Regulatory Environment. Ninth Edition. IRWIN. 1995.
9. Legislative roadmap. A guide for civil society organizations in Tanzania.